

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2023 оны 12 дугаар сарын 19-ний-ны өдөр, Мягмар гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-3

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 4-42

- 
- 1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 4-16
  - 2. Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайханы мэдээлэл сонсох /Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг сонссонтой холбогдуулан зохион байгуулж байгаа ажил, түүний явц, байдлын талаар/* 17-42

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
12 дугаар сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 58 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Б.Саранчимэг, Н.Ганибал, Г.Мөнхцэцэг, Т.Энхтүвшин;  
Чөлөөтэй: Д.Өнөрболор.

**Нэг.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд, Газар тариалангийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Уранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Тэмүүлэн, Х.Наранбаатар, Б.Бейсен нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Тэмүүлэн, Ц.Цэрэнпунцаг, Ж.Батжаргал нар үг хэлэв.

**Ж.Батжаргал:** Гэрийн гэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайханы мэдээлэл сонсох** /Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг сонссонтой холбогдуулан зохион байгуулж байгаа ажил, түүний явц, байдлын талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын шадар сайд С.Амарсайхан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Улсын Онцгой комиссын нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Яаралтай тусламж, гамшиг, биотерроризмын үеийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн Х.Бунд-Очир, Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг сонссонтой холбогдуулан зохион байгуулж байгаа ажил, түүний явц, байдлын талаарх мэдээллийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Г.Ганболд, Г.Тэмүүлэн, Ц.Туваан, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга

Ч.Хишигдалай, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян нар хариулж, тайлбар хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Н.Наранбаатар, Б.Саранчимэг, Ж.Батжаргал, Ц.Туваан, Х.Болорчулуун нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Ж.Батжаргал “Өвөлжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ц.Туваан нар санал хэлэв.

**Ж.Батжаргал:** “Өвөлжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг сонссонтой холбогдуулан зохион байгуулж байгаа ажил, түүний явц, байдлын талаарх Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханы мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 13 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 34 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 32 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
10 цаг 58 минут.

### БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Батжаргал:** Өнөөдрийн Хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн Болорчулуун, Улсын Их Хурлын гишүүн Ганболд, Улсын Их Хурлын гишүүн Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн Идэрбат, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Бейсен нар хүрэлцэн ирснээр ирц 52.6 хувьтай байх тул Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын гишүүн Анандбазар хүрэлцэн ирлээ. Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг гишүүн хүрэлцэн ирлээ. Улсын Их Хурлын гишүүн Аубакир, Саранчимэг, Ганибал, Мөнхцэцэг, Энхтүвшин нар цаг үеийн ажлаар орон нутагт ажиллаж байна. Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор чөлөөтэй байна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг та бүгдэд танилцуулъя.

Нэг. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд Засгийн газрын 2023 оны 11

дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

Хоёр. Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонссонтой холбогдуулан зохион байгуулж байгаа ажилд түүний явц байдлын талаар Монгол Улсын Шадар сайд Улсын онцгой комиссын дарга Амарсайханы мэдээлэл гэсэн ийм хоёр асуудал хэлэлцэхээр орж ирлээ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудал батлагдлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё

**Ургамлын эрүүл мэнд ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн бусад хуулиудын төслүүдийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Болорчулуун танилцуулна.**

Болорчулуун сайдыг мэдээллээ хийхийг урьж байна.

**Х.Болорчулуун:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.10-д хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг гэж заасан ба ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын асуудал нь хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гол үйл ажиллагаа юм.

Монгол Улсын хүнсний гол нэрийн 16 нэр төрлийн бүтээгдэхүүний 65 хувийг ургамал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн эзэлдэг тул ургамлын эрүүл мэндийн асуудал нэн чухал асуудал юм. Монгол Улсын Их Хурлын 2021 оны ар 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 24 он

хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, 22 оны 36 дугаар тогтоолоор баталсан Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан болно.

Монгол Улс Ургамал хамгааллын тухай хуулийг анх 1996 онд баталж, 2007 онд шинэчлэн найруулж өнөөдрийг хүртэл дагаж мөрдөж байна. Энэхүү хүчин төгөлдөр үйлчилж буй Ургамал хамгааллын тухай хуульд ургамал хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагуудын бүрэн эрх, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг голлон зохицуулсан ба ургамлын эрүүл мэнд ургамал хамгаалах үйл ажиллагаа руу чиглэсэн зохицуулалт хангалтгүй байгаа юм.

Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2007 онд батлагдсанаас хойш 1 жилийн дараа буюу 2028 онд Монгол Улс нь Ургамал хамгааллын олон улсын конвенцод нэгдэн орсон. Энэхүү конвенцын стратегийн зорилт хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх замаар тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих, дэлхийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах гэж заасан.

Иймээс Монгол Улс гишүүн орны хувьд ургамал хамгааллын салбарын хууль тогтоомжийг тус конвенцын зарчим, үзэл санаанд нийцүүлэх үүрэгтэй юм. Түүнчлэн Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш хуулийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа зөрчил, дутагдлыг арилгах, нөгөө талаар байгаль орчин нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдан хөдөө аж ахуйн салбарын хамрах хүрээ тэлж, ургамал түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ,

олон улсын худалдаа нэмэгдсэнтэй холбоотойгоор ургамал хамгааллын үй ажиллагааг боловсронгуй болгохын тулд юуны түрүүнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох зүй ёсны шаардлага үүссэн юм.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан болно. Хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Батжаргал:** Болорчулуун сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Цолмонжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Оюунсувд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Уранчимэг.

Хуулийн төслөөс асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Наранбаатар гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн асуултаа асууя.

**Г.Дамдинням:** Хуулийн төслийн өөрчлөлт орж ирж байгаа юм байна. Энэ Ургамал хамгааллын тухай хууль дээр ийм асуулт байна. Бид нар Цэрэнпунцаг гишүүнээр ахлуулсан энэ байгалийн нөөцийг хамгаалах парламентын олон улсын бүлгэмийн гишүүд гээд ажиллацгаадаг. Олон улсын төсөл, хөтөлбөрөөр бид нар маш их



зөвлөх үйлчилгээнүүдийг энэ олон улсын экспертүүдээс авч байгаа. Тэгээд хуучнаараа “Жи Ай Зэт” гэж Германы техникийн тусалцааны байгууллагын шугамаар ирсэн манай бэлчээр, ургамалтай холбоотой судалгаа хийсэн судлаачийн тайланг сонсоход бол бид нар үндсэндээ цөлжилтөд орчихсон. Ер нь экологийн том сүйрэл рүүгээ явж байгаа гэсэн ийм дүгнэлтийг энэ судлаачид нь хийсэн байна лээ олон улсын судлаачид. Энийг ч гэсэн манай энэ салбарын судлаачид бол хүлээн зөвшөөрч бас хэлдэг.

Тэгэхээр Ургамал хамгааллын хууль дээр орж ирж байгаа энэ зохицуулалтууд дээр энэ малын тоо толгойг бууруулах, чанаржуулах, бэлчээр хамгааллыг бий болгох чиглэл рүү ер нь ямар зохицуулалтууд орж ирж байгаа вэ? Хэдэн мянган адуу, хэдэн мянган хэдэн сая ямаа Дундговь энэ аймгуудаа Төв аймгуудаа дуусгаад одоо Хэнтий Дорнод руугаа ороод л ингээд л хядаад л дуусгаад л дуусаж байна л даа. Мал, малаа өсгөөд эдийн засгийн баталгаага хангаад явж байгаа ард иргэд, малчин айл өрхүүддээ бол бид нар энд бурууг өгөх ямар ч боломжгүй. Төрийн зохицуулалт, дэмжлэг тэгээд одоо энэ мянган малаас авч байгаа эдийн засгийн үр өгөөжийг 200, 300 малаас авч болдог энэ зохицуулалт руу нь чиглүүлсэн өөрчлөлтийг бид нар хийх ёстой болчихоод байгаа юм. Цөлжилтөд идэгдээд дуусаж байгаа газар орноо хамгаалах нөгөө талдаа энэ Ургамал хамгааллын хуулийг биелүүлээд явахад энэ малчин өрхүүд энэ уламжлалт мал аж ахуйтайгаа хэрхэн зохицуулах талаар ямар зохицуулалтууд оруулсан юм? Саяын яриад байгаа энэ юманд хамааралтай юмнууд байна уу, үгүй юү? Танай яам л энийг хариуцаад явж байгаа шүү дээ.

Тэгэхгүй зүгээр Байгаль орчны яамны асуудал гэдгээр ингээд хаячихаар Байгаль орчны яам бол байгаль орчноо хамгаална гээд байдаг, мал аж ахуйн салбар хөдөө аж ахуйн салбар болох дээр

зэрэг энэ малын тоо толгойгоо чанаржуулах чиглэл рүү нь энэ яамдууд хоорондоо ер нь ярилцсан юм байгаа юу? Байгаль орчны яамнаас ер нь ямар санал онол ирсэн юм? Ийм хоёр асуулт байна.

**Ж.Батжаргал:** Хариулъя Болорчулуун сайд. Болорчулуун сайдын микрофоныг өгье.

**Х.Болорчулуун:** Дамдинням гишүүний асуултад хариулъя. Энэ бэлчээрийн даац ялангуяа ургамал, Монгол Улсын ургамал бэлчээр их хомсдож байгаа талаар яс ярьж байна. Үнэхээр энэ хоёр нөхцөл байдлаас Монгол Улсын бэлчээрийн даац доройтож байгаа ургамлын бүтэц, бүрэлдэхүүн багасаж байгаа. Энэ нэгд бол дэлхийн дулааралтай холбоотой манай улс бол бас хамгийн их нэрвэгдсэн улс орнуудын нэрвэгдэж байгаа орнуудын нэгд зүй ёсоор тооцогдож байгаа. Ялангуяа манай улсын хувьд баруун болон баруун урдаасаа цөлжилтийн байдал бол эрс нэмэгдсэн. Нийт газар нутаг бэлчээрийн 60-аад хувь нь бол өөрчлөлтөд орсон цөлжилтийн шинж тэмдэг өглөө гэснийг бол олон улсын судалгаа бас харуулж байгаа.

Хоёрдугаарт Монгол улс түүхэндээ байхгүй их малын тоо толгой өсөн нэмэгдсэн. 71 сая толгой мал буюу хонь толгойд шилжүүлбэл 120 гаруй сая толгой хонь малтай болчихож байгаа юм. Энэ хоёр нөхцөл байдлын улмаас ургамлын бүрхэвч, бэлчээрийн нөхцөл байдал өөрчлөлт орж байгаа юм. Тэгэхээр өөрийн чинь хэлдгээр бид зөвхөн бэлчээрийн байдлаар мал аж ахуйгаа адгуулаад тооны хойноос хөөцөлдөх биш бас хагас бэлчээрийн байдал руу шилжих, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх гэж олон жил ярьсан. Гэхдээ үүнийг бол яг бүтээлчээр ажил хэрэг болгохыг цаг үе, цаг агаарын өнөөдрийн нөхцөл байдал ч бас шаардаж байна.

Тийм учраас энэ тал дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

мал амьтны дэглэм бүхий эрүүл бүс байгуулах, хамгаалагдсан аж ахуй байгуулах мөн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах шинэчлэн батлах зэрэг ажлуудыг хийж ирлээ.

Хоёрдугаарт, энэ хуульд ямар арга хэмжээ тусгагдсан бэ гэж байна. Энэ хууль дээр л хуулийн 22 дугаар зүйл дээр ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх гэж байгаа. Энэ дээр ургамал хамгааллын эрүүл мэнд, ургамлын хамгаалах үйл ажиллагаа, нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллана гэж байгаа. Мөн ургамлын эрүүл мэнд, ургамал, хамгаалалттай холбоотой олон улсын хамарсан цахим системд нэгдэх, харилцан мэдээлэл солилцох гэж байгаа. Мөн ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын сургалтыг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран зохион байгуулах, ургамлын эрүүл ахуйн үзлэг хийж дүгнэлт гаргах, тандан судалгаа хийх зэрэг ажлууд багтсан байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

**Ж.Батжаргал:** Дамдинням гишүүн тодруулъя. Дамдинням гишүүний микрофоныг өгөөрэй.

**Г.Дамдинням:** Болорчулуун сайд яах вэ би зориуд хэлээд байгаа санаа нь та хэд маань энэ Байгаль орчны яам энэ тэртэйгээ яриад энэ зохицуулалтуудаа жоохон чангаруулаад, тодорхой болгож өгөөч. Судалгаа шинжилгээний дүгнэлтийг нь аваад л яах юм, биелүүлэхгүй байвал яах юм, шийдэл гарахгүй байвал яах юм? Энэ чинь ямар ч өөрчлөлт орохгүй шүү дээ. Хэдэн цалин авсан дарга суугаад л тэгээд л дуусна биз. Одоо энэ Тариалангийн тухай хууль гээд, бас Газар тариалангийн тухай хууль гээд бас хэрэгжиж өгдөггүй хууль араас нь дахиад ийм Ургамал хамгааллын тухай хууль гээд хэрэгждэггүй хууль гаргах гээд суугаад байж болохгүй байхгүй юу даа хэдүүлээ. Энэ зохицуулалтуудаа тодорхой болгоод яах

вэ хэлэлцэх эсэхийг нь шийдээд явчихъя хэдүүлээ. Ажлын хэсэг дээрээ та нар энэ зохицуулалтуудаа тодорхой болгоод, энэ цөлжилттэй бас энэ хэтэрхий их ачаалал өндөртэй болж байгаа бэлчээртэйгээ зохицуулсан энэ зохицуулалтуудыг бас оруулж өгөөрэй.

**Ж.Батжаргал:** Санал байна.Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

**Г.Тэмүүлэн:** Ургамлын эрүүл мэнд, Ургамал хамгааллын тухай гээд хуулийн төсөл бас орж ирж байна. Хуулийн төсөлтэй холбоотойгоор би агуулгын хувьд тодруулах хэд хэдэн зүйл байгаа. Өвс ургамалтай холбоотойгоор ер нь зүгээр та бүхэн маань өвс, ургамал энэ бэлчээрийн доройтол болоод энэ өвс ургамлын энэ доройтолтой холбоотой асуудал дээр ер нь яг гол нөлөөлөгч хүчин зүйлс нь яг юу гэж үзэж байгаа юм бэ? Би эндээс яг бас түүж гүйлгээд үзэхээр тухайн хорио цээртэй хөнөөлт организм гэж тодорхойлоод байгаа юм.

Тэгэхээр зөвхөн хорио цээртэй хөнөөлт организм гэдгээр л энэ өвс, ургамал болоод бэлчээрийг доройтуулж байна гэж үзээд байгаа юм уу? Яг ямар факторууд байгаа юм? Эдгээр бүх фактортой нь тэмцэх юм уу, эсвэл зөвхөн энэ хорио цээртэй хөнөөлт организм гэдэг зүйл рүүгээ төвлөрч тэмцэх ажлыг хийх юм уу? Яг анхан шатан дээр сум дээр аймаг дээр очихоор энэ хууль ер нь яг яаж хэрэгжих юм бэ? Магадгүй тэр малчин дээр, магадгүй тэр иргэн дээр, магадгүй тэр сумын хөдөө аж ахуйн тасаг дээр, аймгийн хөдөө аж ахуйн тасаг дээр ямар өөрчлөлтүүд гарч, ямар арга хэмжээ, эрх, үүргүүд ноогдож ямар ажлууд хийгдэх ёстой юм энэ хуулийн хүрээнд? Шинэ би бас агентлаг байгуулагдах юм болов уу гэж хараад байна. 22 дугаар зүйл дээр ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэж байна. Тэгэхээр энэ маань Засгийн газар өөрөө дэмжиж байгаа юм уу, шинэ агентлаг байгуулах хүн хүч, орон тоо, төсөв санхүүжилтийн асуудлууд улсын төсөв



дээр яариуухан ачаалууд үүсэх юм бол? Хэрэгжих хугацааг нь харахаар батлагдсан өдрөөсөө гэж байгаа. Тэгэхээр жишээ нь 2024 оны улсын төсөв батлагдсан энэ хүрээндээ ямар зохицуулалтууд хийгдэх ёстой юм? Ер нь манайд хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд өөрөө их дутуу байгаад байдаг.

Тэгэхээр боловсон хүчний хувьд бас хангалттай яг энэ ургамал хамгааллын мэргэжилтнүүд байдаг юм. Жишээ нь магадгүй сум, аймаг болгон дээр бид нар бүтэц, бүрэлдэхүүнийг нь хийгээд явлаа гэхээр хөдөө чинь яг л тэр малын эмч болоод мал зүйч малын зоотехникч нарынхаа хувьд гээд аваад үзэхэд л ер нь л хүрэлцээ муутай. Сум болгонд мэргэжилтэй боловсон хүчнүүд нь байхгүй. Тэр дундаа би ургамлын асуудал дээр гээд аваад үзэхээр боловсон хүчин байх юм уу, үгүй юм уу? Уг нь агуулгын хувьд хувь хүнийхээ үүднээс би боддог байсан зүйл бол ядаж сум болгон дээр ургамал гэхээсээ илүүтэй нөгөө бэлчээр хамгааллын мэргэжилтэн гэдэг юм уу, бэлчээр хамгаалагч ч гэдэг юм уу ийм оронтой бол бас баймаар л юм шиг байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нар ямар зохицуулалтууд хийнэ гэж та бүх маань бас энэ хуулийнхаа төслийг анх боловсруулсан юм бол? Эдгээр асуудлуудаар бас тодорхой тодруулга, мэдээллүүдийг бас авъя гэсэн хүсэлтэй байна.

**Ж.Батжаргал:** Хариульъя  
Болорчулуун сайд.

**Х.Болорчулуун:** 2007 онд Ургамал хамгааллын тухай хууль батлагдан гарсан. Одоо бол нэмээд Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль гэж ингэж орж ирж байгаа. Олон улсад мал амьтдын эрүүл мэнд, ургамал хамгааллын эрүүл мэнд гээд зарим хүмүүс бас гайхаж байна ургамлын эрүүл мэнд гээд. Ургамал чинь өөрөө амьд организм. Тийм учраас цоо шинэ нэр томъёогоор нэршил нь хүртэл өөрчлөгдөж байгаагаар энэ хууль бас онцлог.

Манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр мал эмнэлэг малын эрүүл мэндийг хариуцсан агентлаг байдаг. Та бүхэн мэднэ. Мөн Ургамал хамгаалах хорио цээрийн хэлтэс байдаг юм. Яаман дотроо ер нь цаашидаа олон улсын жишгээр дийлэнх улс орнууд ургамал хамгаалал, ургамлын эрүүл мэндээ хариуцсан ийм тусдаа агентлагтай байдаг юм байна. Ийм агентлаг бий болгох нь зүй ёсны шаардлага болж байгаа юм гэдгийг бас хэлэх байна. Манай хуулийн хэлтэс нэмээд тодруулж хариулт өг л дөө.

**Ц.Болорчулуун:** Ажлын хэсгийн 3 дугаар микрофон Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун.

Тэмүүлэн гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр энэ ер нь энэ Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулиараа бид энэ таримал ургамлынхаа энэ юу бэлчээрийн болон таримал ургамлын хөнөөлт организмын зохицуулалтыг л хийж өгч байгаа. Тэрнээс бусад яг бэлчээрт үзүүлээд байгаа бусад хүчин нөлөө хүчин зүйлүүд гэвэл механикаар болон бусад хүчин зүйлүүд олон хүчин зүйлүүд байгаад байна. Энэ болгон руу зохицуулалтыг хийхгүй. Тэгэхээр энэ чиглэлдээ бол энэ хуулийг ер нь хандуулж бичсэн байгаа.

Дээрээс нь энэ бүтэц орон тоо, агентлаг гэдэг нь түрүүн сайд хэлсэн ер нь Мал эмнэлгийн ерөнхий газрын дайны агентлаг тэгэхдээ бол энэ сумд бид нар бүтэц, орон тоо нэмнэ гэж тооцоолоогүй байгаа. Аймаг дээр болон энэ төвдөө ийм агентлагтай байж байж энэ асуудлаа цогцоор нь харж явахгүй бол бусад орны жишиг, олон улсын конвенцод өгч байгаа чиглэл энэ тэр нь бүгдээрээ ийм бүтцээр энийг зохицуулах ийм зохицуулалттай байгаад байгаа юм. Тийм учраас энэ бүтцийг бид нар тийм байдлаар харж байгаа юм.

**Ж.Батжаргал:** Төсөв, санхүү, боловсон хүчин гэсэн асуултад нь хэн хариулах юм? Та тодруулчих Тэмүүлэн гишүүн.

**Г.Тэмүүлэн:** Би сая төсөв, санхүүтэй холбоотой батлагдсан өдрөөсөө эргэж байна гэхээр энэ чинь 24 оны төсөв батлагдсан байдаг. Тэгэхээр шинэ хүн хүч гэдэг юм уу, орон тоо, төсөв санхүүжилтийн асуудлууд нэмэгдэх асуудал үүсэх вий. Боловсон хүчний хувьд нөөц бололцоо энэ агентлаг байгуулаад гэдэг юм уу анхан шатан дээр ер нь нөхцөл бололцоо нь байгаа юм уу?

Хоёрдугаарт энд агентлагийн хийх бүрэн эрхийн асуудал дээр болохоор ургамлын эрүүл ахуйн үзлэг хийж, дүгнэлт гаргах гэж орж ирсэн байгаад байгаа. Тэгэхээр би зүгээр эхлээд үзлэг хийхээсээ өмнө бид нар жишээ нь нэгтгэж бүртгэлжүүлэгч гэдэг юм уу, энэ хадгалж хамгаалах, судалж хөгжүүлэх гэдэг юм уу энэ асуудлууд нь ер нь тусгагдсан юм уу? Жишээ мэдээж яг юун дээр үзлэг хийх вэ? Бүх нийт жид дээ бэлчээр болоод ургамал дээр нь үзлэг хийх юм уу, эсвэл төрөл зүйл болгоноо бүртгэлжүүлж нэгдсэн мэдээллээс эхлээд нэгтгэж аваад дараа нь ингээд бусад ажлууд нь хийгдээд явах ёстой юм уу? Энэ дээр сан, бүртгэл мэдээлэлтэй холбоотой асуудлууд нь яаж хийгдэх ёстой юм бол?

**Ж.Батжаргал:** Хариулъя, 3 номер.

**Д.Есөн-Эрдэнэ:** Би ярьчихъя. Тэмүүлэн гишүүний асуултад тодруулж хариулъя. Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ. Хууль үндсэндээ ургамал хамгааллын үндэсний байгууллага байна гээд байгаа. Ургамал хамгааллын үндэсний байгууллага нь энэ холбогдох энэ оролцож байгаа бүх байгууллагуудын мэдээллүүдийг нэгтгэж авна эхний ээлжид. Энэ мэдээллийн сантай байна гэсэн зохицуулалт бол энэ хууль дээр бас орж байгаа. Илүү таримал ургамал

болон бэлчээрийн ургамлын хөнөөлт организм, түүний тархалт, энэ чиглэлийн хөнөөлт, хорио цээрийн энэ асуудлуудыг л бүхэлд нь зохицуулсан ийм хууль байгаа. Байгаль орчны яаман дээр бол тодорхой ажлууд бас хийгдээд явж байгаа. Тэрний мэдээллүүдийг энэ Ургамал хамгааллын үндэсний байгууллага дээрээ авна. Мөн Боловсрол, шинжлэх ухааны яамны Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн байгаа. Тэнд бас зохицуулалтын ажил.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Гүйцээж хариулъя 3 номер, ажлын хэсгийн.

**Д.Есөн-Эрдэнэ:** Тэн дээр Ургамал хамгааллын хүрээлэн гээд бас тэнд том байгууллага ажиллаж байгаа. Энэ дээр бол энэ бэлчээр болон таримал ургамалд энэ тандан судалгаануудыг бол байнга хийдэг. Энэ гадаадад экспортлох, импортлох энэ асуудал дээр бол энэ тандан судалгааг хийх асуудлууд бас тавигддаг. Энэ асуудлуудыг бол бас энэ ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгээр хийлгэх ийм зохицуулалтууд бас байгаа. Гааль дээр бас гаалийн байцаагч нар, хорио цээрийн байцаагч нар байгаа. Тэр байцаагч нар энэ хуулийн дагуу бас манай яам агентлаг руу шилжиж ирэх ийм ажиллах ийм боломж юутай байгаа юм бүтцээрээ. Энд үндсэндээ аймаг дээр бол хөдөө аж ахуйн газрын энэ ургамал хамгааллын газар тариалангийн албатай болно. Манай юун дээр бас энэ алба байгуулагдана. Хуучин бол бас Ургамал хамгааллын үндэсний алба гэж байсан. Үүн шиг Ургамал хамгааллын алба байгуулагдаад энэ зохицуулалтын ажлуудыг хийдэг л ийм алба байгуулагдах юм байгаа юм.

**Ж.Батжаргал:** Болорчулуун сайд. Болорчулуун сайдын микрофоныг өгөөрэй.

**Х.Болорчулуун:** Засгийн газар шинээр агентлаг байгуулахгүй гэсэн. Тэгэхээр энэ 24 оны эхний хагас жил

хүртэл бол мэдээж агентлаг төсөв, мөнгө нь 24 онд төсөвтөө тавиагүй болохоор байгуулагдахгүй нь ойлгомжтой. Ер нь хоёрдугаар хагаст төсөв хэлэлцээд эхлэхэд энийг нарийвчилж, төсөвт суулгаж тусдаа агентлаг болгон гаргах дээр бол бид ажиллах ёстой гэдэг ийм бодолтой төлөвлөлттэй байна.

Цаашилаад сая хэллээ Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяанд байдаг тэр ургамлын хүрээлэн, мөн тэр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд харьяа байгаа Газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн энэ тэрийг бол яг мэргэжлийн яаман дээрээ урьд нь бол тийм байсан шүү дээ манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр байсан. Энд бол татаж авчрах нь зүйтэй. Улс оронд бүгд тийм харьяа яамандаа байдаг.

**Ж.Батжаргал:** Тэмүүлэн гишүүн нэмж тодруулах зүйл байгаа юм уу?

**Г.Тэмүүлэн:** Сая яамны газрын дарга бас жоохон дутуу л хариулаад байх шиг байна. Би дахиад нэмж тодруулж асууя гэх гээд байгаа юм.

Нэгт, Генетик нөөцийн тухай хууль гээд байгаа энэ хуультайгаа яаж уялдаж байгаа юм бол? Тэр дээр чинь бол яг энэ ургамлын бүртгэл, мэдээлэлжүүлэлт болоод, хадгалах хамгаалах, судлах асуудлууд маань өөрөө тэнд бүрэн тусчихсан байгаад байгаа юм.

Хоёрт, Байгалийн ургамлын тухай гээд, Ойн тухай гээд бас хуулиуд байгаад байгаа юм. Эд нар маань хоорондоо бас яаж уялдаад байгаа юм.

Гуравдугаарт, би анхан шатан дээр амьдрал дээр очихоор яаж хэрэгжих юм бэ гэдэг асуудал байгаа юм. Магадгүй тэр хөдөө орон нутгийн тэр суман дээр, баг дээр очихоор. Би хүсэж байгаа зүйл нь тэр нөгөө өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, шавж ч гэдэг юм уу, бүүр

энгийнээр нөгөө үлийн цагаан оготно байна шүү дээ тэрэнтэй тэмцэх ажлыг жишээ нь энэ хуулийн хүрээнд зохицуулна гэсэн зохицуулалтуудыг нарийвчилж оруулж ирж энэ агентлаг маань энэн дээр анхаарал хандуулж, ингээд юу гэдэг юм устгах, хамгаалах ажлуудыг хийгээд явах юм уу?

**Ж.Батжаргал:** Хариулъя. Ажлын хэсгийн 9.

**Д.Есөн-Эрдэнэ:** Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ. Байгалийн ургамлын тухай хууль бол бас энэ хамаарах зарим асуудлууд нь бас хамаарагдана. Энэ генетик нөөцийн асуудлууд нь бол энэ тусдаа явж байгаа. Энэ генетик нөөц нь хамгааллын асуудал нь бол тэрний генетик нөөц бол олон хүчин зүйлээс хамаарч бас энэ яахгүй болдог, зохицуулалт яадаг. Энэ Ургамал хамгааллын тухай хууль нь бол энэ олон улсын ургамал хамгааллын конвенц гээд байгаа. Энэ конвенцоороо бол илүү хөнөөлт организмыг яаж хамгаалах вэ, яаж урьдчилан сэргийлэх вэ үндсэндээ өвчин, хортон мэрэгч, шавж гээд ийм илүү энэ хөнөөлт организм энэ ургамалд үзүүлдэг хөнөөлт организмаасаа хэрхэн яаж урьдчилан сэргийлэх вэ, хэрхэн яаж хамгаалах вэ гэсэн энэ асуудлууд чиглэгд.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** 3 номерын микрофоныг өгчих. Гүйцээгээд хариулаадах.

**Д.Есөн-Эрдэнэ:** Генетик нөөцийн асуудал нь илүү ургамлын гений санг хамгаалах тал дээр нь илүү чиглэгдэж байгаа юм. Үндсэндээ амьтан, ургамал дээр аваад үзэх юм бол нь болохоор амьтны эрүүл мэндийн асуудлууд нь мал, амьтны эрүүл мэндэд, нөгөөдөх нь бол мал, малын удмын сан, генетик нөөцийн асуудлууд ч гэсэн ийм хоёр хил зааг, ийм хязгаартай байгаа юмаа гэдгийг. Тийм ургамал.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Тийм ургамлынхаа л юмыг л ярина л даа. Наранбаатар гишүүн асуултаа асууя. Та санал дээрээ яачих.

**Н.Наранбаатар:** Энэ ургамал хамгааллын асуудал бол бас чухал асуудал л даа. 2007 онд батлагдсан хуулиар хаягдсан, орхигдсон зүйлүүдийг бас илүү нарийвчлаад олон улсын гэрээ конвенцод тааруулаад орж ирж байгаа юм байна. Энэ дээр бас ийм юм энэ үзэл баримтлал дээр хуулийн төсөл батлагдсан дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар гэдэг дээр ерөөсөө тооцоолол янз бүрийн юм байхгүй байна шүү дээ. Энэ хуулийн чинь юуг харахаар зэрэг Засгийн газрын дэргэдэх агентлаг байгуулна гээд. Агентлаг байгуулахаар чинь төсөв, зардал гээд зөндөө зүйлүүд нэмэгдэнэ.

Тэгэхээр энэ дээр ямар тооцоолол байгаа юм? Аль эсвэл шинээр бүтэц, орон тоо нэмэгдэхгүйгээр одоо байгаа тэр Боловсролын яамны харьяа байгууллагыг шилжүүлээд төсөвтэй нь авчраад явах юм уу? Орон нутаг болон аймаг, сум хилийн боомтууд дээр орон тоо нэмэгдэх юм уу, нэмэгдэхгүй юм уу? Одоо тэнд ажиллаж байгаа гаалийн эрүүл ахуйч нарыг бол шилжүүлээд энэ агентлагийн харьяандаа ажиллах юм уу? Энэ нь ерөөсөө энэ хуулийн үзэл баримтлалд тодорхой хэлсэн, тодруулсан зүйл байхгүй байх юм. Энэ дээр би тодруулга аваадахъя даа. Цоо шинээр агентлаг байгуулаад бүтэц, орон тоо боловсон хүчин болох гээд байгаа юм уу, одоо байгаа бүтэц, орон тоо, төсөвтөө багтаагаад энэ агентлаг үйл ажиллагаагаа явуулах юм уу?

**Ж.Батжаргал:** Хариулъя  
Болорчулуун сайд.

**Х.Болорчулуун:** Энэ ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын шинээр агентлаг байгуулахад мэдээж тодорхой хэмжээний зардал нэмэгдэнэ. Тэгэхээр би түрүүнд хэлдэг 24 оны төсөв дээр шууд суулгаагүй байгаа. Эхний хагас жилд бол

энэ асуудал бол шийдэгдэж чадахгүй нь ойлгомжтой. Цаашидаа хоёрдугаар хагас жилд улсын төсөв, төлөвлөгөөнд 25 онд тэр суулгах байдлаар агентлагаа л байгуулахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсэж байгаа юм л даа. Тэрнээс биш хуучин байгаа юмыг шууд нэгтгээд механикаар энэ оны хагас жил дотор яах боломж хомсоо гэдгийг бас хэлэх тийм.

**Ж.Батжаргал:** Наранбаатар гишүүн тодруулъя. Наранбаатар гишүүний үг өгөөрэй.

**Н.Наранбаатар:** Шинээр агентлаг байгуулахлаар нөгөө Төрийн хэмнэлтийн хууль, нөгөө төрийн албан хаагчдын тоог 15 хувиар бууруулах чиглэл энэ тэр гээд энэ хуулиудтайгаа зөрчилдчихгүй юу? Бусад хуультайгаа зөрчилдсөн тийм л хуулийн төсөл бид нар дэмжих гээд л байх шиг байх юм. Засгийн газраас ямар санал өгсөн юм бол?

**Ж.Батжаргал:** Хариулъя. Ажлын хэсгийн 3 номер.

**Ц.Болорчулуун:** Наранбаатар гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр энэ олон улсын байгууллагаас тавьж байгаа шаардлага нь энэ заавал бүтэцтэй байх ёстой гэсэн ийм шаардлага байгаад байгаа. Үндэсний байгууллага байх ёстой гэсэн. Бид нар бол хуулийн төслийг боловсруулаад Сангийн яамнаас энэ талаараа санал авсан энэ үр нөлөөний судалгаан дээрээ нийтдээ 11 хүний 850 орчим сая төгрөгийн ийм зардал байх юм байна гэсэн ийм тооцоо судалгаа хийсэн. Сангийн яам бол энэ дээр ямар нэгэн эсрэг санал өгөөгүй, зөвшөөрсөн санал өгсөн байгаа. Тэгэхээр үүгээрээ бол бид нар засгаар дэмжүүлээд оруулж ирсэн байгаа гэж хэлье.

Ер нь бол одоо 24 онд төсөвтөө байхгүй учраас одоо явж байгаа байгууллагуудын хоорондын тэдгээрээр гүйцэтгүүлж хоорондын уялдаа харилцааг нь зохицуулах замаар 1 жилээ явуулж болохоор байна гэсэн ийм



урьдчилсан тооцооллоо хийсэн байж байгаа.

**Ж.Батжаргал:** Бейсен гишүүн асуулт асууя.

**Б.Бейсен:** Ургамал хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дэмжиж байгаа юм. Ургамал хамгаалах хууль анх 96 онд батлагдсан, 2007 онд шинэчилсэн найруулга хийгдсэн. Үүнээс хойш зөндөө юм болж байна. Монгол Улсын газар нутгийн 76.9 хувь нь цөлжсөн бэлчээрийн даац хэтэрсэн, өвс, ургамлын төрөл зүйл цөөрсөн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлт агаарын бохирдол мөн сүүлийн жилүүдэд уурхай эрчимтэй хөгжиж байгаатай холбоотой газар их хэмжээгээр сүйтгэгдэж байгаа. Үүнээс гарах гаргалгаа юу юм бэ? Ямар ургамал газрын хөрсийг хамгаалах вэ? Энэ дээр чинь 2007 оноос хойш ургамлын хэчнээн төрөл зүйл устгаж үгүй болсон юм бэ. Судалгаа хийсэн юм байна уу?

Хоёрдугаарт бэлчээрийн даац хэтэрсэн үнийг яаж зохицуулах вэ, ямар зохицуулалт хийх гэж байна Хөдөө аж ахуйн яамны зүгээс. Малын эрүүл мэндтэй холбоотой асуудал байна. Ургамлын гаралтай малын өвчлөл их гарч байна энэтэй яаж тэмцэж байна? Улаанбаатар хотын агаарын бохирдол сайжруулсан түвшинээс болоод жишээлбэл сүүлд хүхэр баас хэрэглэж байна л гээд ярьж байна шүү дээ. Энэ үнэн үү? Үүтэй холбоотой Улаанбаатар хот орчим хэчнээн ургамал устаж үгүй болж байна, судалгаа хийсэн юм байна уу? Эмийн ургамал хамгаалах, тариалах, ургуулах талаар ямар бодлого баримталж байна энэ талаар асууя.

**Ж.Батжаргал:** Болорчулуун сайд хариулъя. Болорчулуун сайдын микрофоныг өгөөрэй.

**Х.Болорчулуун:** Бейсен гишүүний асуулттай холбогдуулж ярихад тэр сүүлийн жилүүдэд 2007 оноос хойш ер нь хэдэн төрлийн ургамал устаж үгүй болж байна ийм судалгааг асууж байна. Энийг

Байгаль орчны яам илүү судалгаа гаргах ёстой, мөн Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа тэр Ургамал судлалын хүрээлэн энэ дээр илүү судалгааг гаргана. Би түрүүний хэлдэг энэ Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяанд байгаа тэр Ургамлын хүрээлэн, Ургамал судлалын хүрээлэн, мөн газар тариалангийн эзэмшлийн хүрээлэнг яг мэргэжлийн яамандаа, салбарын яамандаа олон улсын жишгийн дагуу ирүүлэх нь уг нь зүйтэй байхгүй юу. Тэгэхгүйгээр ингээд сарнигчаад Боловсрол, шинжлэх ухааны яам ч анхаарсан ч юм байхгүй. Ялангуяа Газар тариалангийн хүрээлэн эд нар дээр хөрөнгө оруулалт хийдэггүй, хуучны үеэрээ л техник технологитой ингээд л социализмын үеийн хэдэн боловсон хүчин, докторууд л тэрийг авч явж байгаа тийм шинжтэй л байгаа шүү дээ. Энэ дээр бид нар бас өөрчлөлт гаргах цаг нь болсон.

Хуучин Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн манай Байнгын хороогоор харьяа салбарын яаман дээр нь энэ хүрээлэнгүүдийг аваачъя гэсэн ийм тогтоол гаргасан юм. Гэтэл одоо тухайн үеийн Нийгмийн хамгаалал, боловсрол, шинжлэх ухааны байнгын хороо бид нар өгөхгүй гэсэн бас тогтоол нөгөө талдаа гаргаад бас хоёрдмол байдалтай байж байгаа юм.

Тэгэхээр таны тэр асуултад бол илүү тэр хүрээлэн болон Байгаль орчны яамныхан хариулах болно гээд хэлье.

**Ж.Батжаргал:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо хуулийн төслийн танилцуулгатай холбогдуулж санал хэлэх гишүүд нэрсээ өгье. Санал хэлэхээр нэрсээ өгч байгаа гишүүдийг бүртгэлд аваарай. Дамдинням гишүүн, Тэмүүлэн гишүүн, Цэрэнпунцаг гишүүн. Гурван гишүүн байна. Цэрэнпунцаг гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн санал хэлье.

**Г.Дамдинням:** Энэ Ургамал хамгааллын тухай хуулийн төслийг



хэлэлцэх эсэхийг нь бол дэмжээд явчихъя. Тэгэхдээ учир дутагдалтай юм их байна. Бэлчээртэй холбоотой зохицуулалтыг энэ хууль дээр нэлээн тодорхой тусгаж өгмөөр байна Хөдөө аж ахуйн яамныхан. Дан ганц олон улсын байгууллагуудын өгч байгаа шаардлага нь энэ юм гээд араар нь нуугдаад байж боломгүй байна. Аль олон улсын байгууллагын өгч байгаа чиглэлийн дагуу агентлаг байгуулаад явах ёстой байдгийг би мэдэхгүй. Түрүүн бас гишүүд хэлж байна Засгийн газар нэмж агентлаг байгуулахгүй, төрийн бүтцийг данхайлгахгүй, төрийн албан хаагчдын тоог хязгаарлана гээд хууль гаргаад баталчихсан байж байхад нэмээд л агентлаг байгуулна гээд л оруулаад ирж байгаа байхгүй юу.

Тэгээд одоо салбар болгонд агентлаг байгуулаад яваад байвал энэ чинь тоо нь зогсохгүй шүү дээ. Бэлчээртэй холбоотой зохицуулалтыг Газрын тухай багц хууль дээр өргөн барьсан, хэдэн заалтаар зохицуулна гээд яваад байгаа. Газар байна, газар дээр чинь өвс, ургамал ургана. Өвс, ургамлын тухай ярих гэж байгаа бол энэ бэлчээр чинь яригдана л гэсэн үг шүү дээ. Та нар энэ зохицуулалтаа бас оруул л даа.

Тэгэхгүй бид нар энэ агентлаг байгуулах ч хэдэн хүн ажилтай болгох тухай хууль батлаад хэрэггүй л байхгүй юу. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал та нар энэ байгаль хамгаалах, ургамлын нөөц хамгаалах гээд байгаа бол Байгаль орчны яамныхныг энэ ажлын хэсэгтээ оруул. Танай яаманд энэ хөдөө аж ахуй, газар тариалан, малтай холбоотой асуудлууд нь байгаад байгаа юм байгаа биз. Тэгвэл бас тэр Боловсролын яамны энэ агентлагуудыг нь авна гэж байгаа бол тэр хүрээлэнгүүдийг нь авна гэж байгаа бол тэр Боловсролын яамныхныг бас энэ ажлын хэсэгт нь оруул л даа. Хоёр салбар хоорондоо хэрэлдээд л агентлаг булаацалдаад байгаа асуудал болоод сүүлд нь дуусна шүү дээ.

Тэгэхээр энэ нэгдүгээрт энэ ажлын хэсгээ байгуулахдаа энэ салбарын яамнуудаа оруулж байгуулмаар байна.

Хоёрдугаарт энэ бэлчээртэй холбоотой асуудлыг энд зохицуулж оруулмаар байна.

Гуравдугаарт ганцхан энэ олон улсын байгууллагуудын шаардлага гэдэг тайлбараасаа гадна Монгол орныхоо амьдрал, нөхцөл боломжид таарсан өөрчлөлтийг зайлшгүй хийх хэрэгтэй байна гэдгээрээ наад тайлбар, судалгаа юмнуудаа нэмж хийгээд танилцуулаач. Энэ хуулийг батлаад хэдий хэмжээний зардал гаргаад татвар төлөгчдийн мөнгөнөөс, хэдий хэмжээний орлого олох гээд байгаа юм. Орлого нь мөнгөөрөө биш гэхэд байгаль орчныг хэдий хэмжээнд хамгаалах гээд байгаа юм? Хэдэн га газар хэдэн мянган га газрыг бид нар хамгаалах гээд байгаа юм энэ хуулиар, яаж зохицуулах гээд байгаа юм? Экспортын бараа бүтээгдэхүүнийг эндээс яаж бий болгох гээд байгаа юм? Тэр тооцоогоо танилцуул л даа. Олон улсын байгууллагуудын зөвлөмж, I агентлаг байгуулах хэрэгтэй, олон улсад ингэж явдаг юм гэж яриад байхаар чинь энийг чинь дэмжих боломжгүй болж эхэлж байна шүү дээ сүүл рүүгээ. Яах вэ та нар ажлаа явуулах гэж байгаа гэвэл ойлгож байна.

Тэгэхээр манай Хөдөө аж ахуйн яамныхан энэ бэлчээрийн зохицуулалт, Тариалангийн тухай хууль, энэ хөрстэй холбоотой асуудлууд, байгаль хамгаалалтай холбоотой асуудлуудаа нэгэнт та нар агентлаг байгуулах гээд байгаа бол энэ бүгдийг нь хамарсан бодлогоо зохицуулаад оруулж ирсэн энэ хуулийн уялдаа холбоогоо тааруулж оруулж ир. Ингээд явбал энэ хуулийг чинь дэмжээд явъя гэсэн ийм л бодолтой байна. Хэлж анхааруулсан юмаа хуулийн төсөл хэлэлцэгдээд анхдугаар хэлэлцүүлэг нь явах үед нь асууна шүү. Баярлалаа.

**Ж.Батжаргал:** Дамдинням гишүүнд баярлалаа. Одоо Цэрэнпунцаг гишүүн үг хэлье.

**Ц.Цэрэнпунцаг:** Бид нар түрүүн Дамдинням гишүүн бас энэ бүлэг дээр чинь байгаль хамгаалах бүлэг гээд Их Хурал дээр чинь бүлэг байгаа. Энэ бүлгийнхэн бас сайн ажиллаад энэ гаднаас төсөл хэрэгжүүлж байгаа юм. 600 мянган долларын олон улсын байгаль хамгаалах энэ байгууллагуудаас 600 мянган доллар гэдэг чинь юу вэ хоёр аравны хэдэн тэрбум төгрөгийн төсөл байгаа юм. Энэ нь ямар төсөл юм гэхээр зэрэг энэ хуулиудыг ялангуяа энэ байгаль орчныг хамгаалах, байгаль орчны энэ асуудалтай холбоотой, бэлчээртэй холбоотой энэ ургамал, ус, ургамалтай холбоотой, цаашилаад яривал энэ жижиг гар аргаар уул уурхай олборлодог энэ ер нь байгальтай харьцаж байгаа энэ олон харьцааг зохицуулж байгаа хуулиудын хоорондын уялдаа холбоог хангах, давхардал, хийдлийг арилгах ийм төсөл явж байгаа юм. Тэгээд энд холбоотой тэр явагдаж байгаа хуулиудыг явагдах орж ирж байгаа, Засгийн газраас өргөн барих гэж байгаа, өргөн барьсан Их Хурал дээр байгаа хуулиудыг энэ нэрсийг нь өгөөд ингэсэн юм. Энэ жагсаалтад оруулж өгсөн юм уу? Би түрүүн асуулт асуух гэж байгаад амжсангүй. Энэ жагсаалтад оруулаад уул нь энэ дунд оруулаад явчихвал их олон асуудал шийдэх юм байгаа юм.

Яагаад гэвэл гаднын хуулийн фермүүд, хуульчид, дээрээс нь дахиад тэр атлас гээд бас ерөнхий технологи ашиглаад бас энэ хөгжүүлэлт хийчихсэн ийм аргачлал боловсруулж байгаа Европын компани эд нар зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа. Тэгэхээр энэ хууль дээр энэ хуулиудыг нь тэрэнд оруулаад эхнээс нь цэгцтэй явбал уул нь хэрэгтэй юм байгаа юм.

Тэгээд бид нарын гол ойлголт бол энэ Ургамал хамгааллын хууль гээд нэрээс нь хүртэл харахад ургамал гэхээр мэдээж энэ таримал ургамлууд байгаа,

тэгээд манай ихэнх нутаг энэ бэлчээр эзэлдэг, энэ бэлчээрээ л хамгаалах гэж ойлгогдоод байгаа шүү дээ. Бэлчээр хамгаалахад яг бодитой энэ хууль чинь хэрэгжиж эхлээд нэгмөр оруулах юм уу, үгүй юу? Эсвэл нэр төдий хууль гаргах гэж байгаа юм уу. Энэ хууль бол хангалттай олон байгаа шүү. Долоо, найм, есөн зуун хуультай хэрэгждэггүй. Хэрэгжүүлдэггүй хуулиуд ингэж гаргаад байх ер нь ямар шаардлага байгаа юм.

Дээрээс нь энэ Засгийн газраа ингээд л бүтэц нэмээд л, ингээд л зардал, чирэгдэл нэмэх, нэмсэн ийм л юмнууд л хийгээд яваад байх юм. Энэ чинь Засаг данхайгаад, дээрээс нь энэ хувийн хэвшлийнхнийг шахаад, данхайгаад цээж нь томдчихсон хоёр хөл нь тулж явдаг тулгуурууд нь нарийдчихсан муудчихсан тийм л хүчтэй салхи гарвал уначихаар болсон эдийн засагтай болж байж яах нь вэ. Тийм яаралтай биш юм бол энийгээ татаад авчих хэрэгтэй байна Засгийн газар.

**Ж.Батжаргал:** Цэрэнпунцаг гишүүнд баярлалаа. Одоо Тэмүүлэн гишүүн үг хэлнэ.

**Г.Тэмүүлэн:** Засгийн газраас өргөн баригдсан Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль орж ирсэн. Энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад мэдээж Байнгын хороон дээр, Улсын Их Хурал дээр ажлын хэсэг бол гарах байх. Би уялдуулах зүйл нь анхаарах гол зүйл нь бол яах вэ ургамал гэдэг асуудал маань өөрөө өвс, ургамлын асуудлууд. Энэ өөрөө нэг талдаа бас бэлчээрийн асуудал. Монгол Улсын хөдөө аж ахуйн салбартай салшгүй холбоотой асуудал.

Тэгэхээр бид нар энэ хоёр хөдөө аж ахуйн салбарын хоёр багана болсон энэ асуудлыг л бид нар зөв зохицуулах л хууль гарах ёстой л гэж хараад байгаа юм л даа. Газар тариалан болоод мал аж ахуйн салбарын. Та бүхэн маань болохоор энэ хууль дээрээ илүү би анзаарч байхад тариалан руугаа түлхүү анхаарчихсан

юм биш үү. Тариалангийнхаа тэр ургамлынхаа эрүүл ахуйн тал руугаа тэрийгээ хадгалах, хамгаалах тал руугаа л анхаарчихсан юм биш үү л гэж би бас хууль зүйн талаасаа хараад байгаа. Тэгэхдээ нарийвчилж сайн үзээгүй байна. Жишээ нь энэ чинь Ургамлын тухай хуулийн 23.3-д заасан мэдээллийн санд ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын дэд санг бий болгох гэдэг асуудлыг тавиад байгаа байхгүй юу.

Тэгэхээр Тариалангийн тухай хуулийн мэдээлэл тариалангийн мэдээллийн сангийн доор дэд сан бий болгон ургамалтай холбоотой гэсэн асуулт тавиад байгаа юм. Уг нь би явж явж явах нь бол энэ Генетик нөөцийнхөө хууль, түрүүн тэр Малын генетик нөөцийн тухай хууль андуурч яриад байх шиг байгаа юм. Малын генетик нөөцийн хуулиас чинь гадна дахиад Генетик нөөцийн тухай хууль байгаа байхгүй юу. Түүгээрээ энэ ургамлын чинь хадгалах, хамгаалах, ашиглахтай холбоотой асуудлууд харилцаа нь орж ирж байгаа. Тэнд чинь бас мэдээллийн нэгдсэн сангийн асуудал байгаа. Өвс, ургамалтай холбоотой, бэлчээр хамгаалалттайтай холбоотой зохицуулалтуудтай байгаа. Тэгэхээр би жишээ нь тэн дэх мэдээллийн сан дээр төвлөрч очих ёстой юм биш үү нэг талдаа? Энэ асуудлуудаа яг зөв зохицуулж, төвлөрч харахгүй бол зөвхөн тариалан руугаа чиглэсэн тэр өвс, ургамлаа хадгалдаг, хамгаалдаг ч гэдэг юм уу ийм хууль болчих вий гэсэн болгоомжлол байгаад байгаа юм.

Нөгөө талдаа одоо бол сая бас гишүүд ч хэлж байна хэд хэдэн уялдуулах хуулиуд байгаа шүү. Ойн тухай хууль байгаа, Байгалийн ургамлын тухай хууль гэж бас байгаа. Би энэ бэлчээртэй холбоотой асуудлууд дээр уялдуулах энэ бэлчээр хамгааллын асуудлуудыг нь тавих, зөвхөн ургамал хамгааллын мэргэжилтэн гэх юм уу, эсвэл бэлчээр хамгааллын мэргэжилтэн ч гэх юм уу энэ асуудлуудаа нэг талдаа бас анхан шатан дээр нь хэрэв үнэхээр бүтэц, нэгж байгуулах гэж бодож байгаа бол

дараагийн жилийнхээ төсвөөсөө энэ нэгжийг нь зөв, зохистой бүтэц бүрэлдэхүүн, утга агуулгаар нь уг нь гаргаад тавих нь бол зөв байх гэж хараад байгаа юм. Тэгэхгүй бол анхан шатад очихоор бэлчээр тэжээл мэддэг ч хүн байхгүй тэжээл тариалалттай холбоотой асуудлуудыг.

Үндсэндээ мал аж ахуйн салбарыг бид нэмэлт бэлчээр, хадлан талбай бий болгоё гэвэл нэмэлт тэжээл тариалахаас өөр гарц байхгүй. Тэгэхээр энэ рүү чиглэсэн мэргэжлийн боловсон хүчин, тэжээлийн асуудал хариуцсан юу гэдэг юм яг мал аж ахуйн салбар дээр тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн тэр сум орон нутагт байх ёстой ч гэдэг юм уу, газар тариалангийн бүс нутагтаа бол ургамал хамгааллын мэргэжилтэн ч гэдэг юм уу ийм зохицуулалтуудыг баланслуулаад хийх ёстой байх гэж хараад байгаа юм. Тэгж байж юу гэдэг юм цаашидаа энэ магадгүй хууль маань өөрөө хэрэгжих хөшүүрэгтэй, бүтэц, нэгжтэй амьд нэг ийм хууль болох болов уу л гэж хараад байдаг.

Тэгэхээр энэ дээр илүү түлхүү бас анхаарч ажиллах нь зөв байх Байнгын хорооны зүгээс. Одоогийн байдлаар бол би илүү тариалан тал руугаа л анхаарсан ийм хууль байна уу даа гэсэн ийм зохицуулалтууд байна л гэж харж байгаа. Тэгэхээр холбогдох бусад Генетик нөөцийн тухай хууль болоод Ургамал хамгаалал, Байгалийн таримал ургамлын тухай хуулиуд ч гэдэг юм уу эд нартайгаа уялдуулах, уялдаа нийцлийг нь хангах тал дээр л анхаарч ажиллах нь зөв байна л гэж харж байна.

**Ж.Батжаргал:** Тэмүүлэн гишүүнд баярлалаа. Надад ганц санал байна. Хуулийн ерөнхийдөө үзэл баримтлал, хүрээ энэ тэр бүх юмыг харахаар зэрэг биднүүс ургамлынхаа эрүүл мэнд талыг давамгайлж бариад боловсруулчихсан юм билээ. Тэр хамгаалал гэдэг үг нь тэрний цаана хамрагдах юмнууд нь нэлээн тийм

хязгаарлагдмал юм хийгдчихээ л гэж ингээ л харагдаад байна л даа.

Тэгэхээр нийт нутаг дэвсгэрийн маань энэ чинь 70 гаруй хувь нь бэлчээр байгаад байдаг. Энэ бэлчээрийнхээ ургамлын хамгаалалтын асуудлыг хэдүүлээ юу гэж ойлгох юм? Тэнд өнөө хөнөөлт организм гэдэг юм чинь байна уу, үгүй юү гэдгийг яаж тандан судлах юм? Түүнээс яаж урьдчилан сэргийлж хамгаалах ёстой юм, үүссэн нөхцөл байдал бий боллоо бол түүнтэй ямар аргаар яаж тэмцэх вэ гэдэг юм нь өөрөө байх ёстой юм шиг байгаа юм нэг.

Хоёрдугаарт таримал ургамал байна. Энэ дээр бид бас илүү нарийсгаж хармаар байгаад байдаг. Сүүлийн 2, 3 жил наад үр тариан дээр чинь, төмс дээр чинь тодорхой өвчлөлтүүдийн тухай яриад эхэллээ шүү дээ чийгийн өвчин энэ тэр гээд. Үүнийгээ тэр аж ахуй эрхэлж байгаа улсууд нь яаж мэдээлэл юмнуудаа дамжуулах ёстой юм, энэ аж ахуйн нэгжүүд дээрээ мэргэжлийн удирдлага гэдэг юм нь ямархуу улсууд байх юм? Тэднүүсийн эрх, үүрэг юмнуудыг их тодорхой болгож өгч, түүнтэй тэмцэх чиглэлийн ажлаа яаж хийх вэ эд нар гээд бодмоор, анзаармаар ийм зүйлүүд бидэнд байгаад байгаа юм.

Нөгөө талд ойн. Энэ ойн зохион байгуулалтынхаа хүрээнд тодорхой хэмжээний хортон мэрэгчид гэж биднүүс яриад байдаг. Та нар болохоор хөнөөлт организм гээд тэр олон улсын шинэ нэр томъёоллоор оруулаад ирж байгаа юм шиг байгаа юм. Түүнд өртөгдсөн талбайн хэмжээ хэд байгаа юм бэ, түүнтэй яаж тэмцэх юм бэ гэдэг асуудлууд байгаа. Энэ ажиллагааны хөрөнгийн асуудлыг яаж шийдэх вэ гэдэг асуудал байгаа юм. Энд зохицуулж өгмөөр байгаа юм. Өнөө урт нэртэй хуулиар төлбөрийн орлого хаана орж байгаа билээ. Тэрний хэдэн хувийг буцаагаад өнөөхтэй тэмцэх ажилд зарцуулдаг билээ биднүүс.

Тэгэхээр энэ хууль хоорондын уялдаануудыг зөв ашиглах тухай л асуудал байгаад байна л даа. Та хэд маань бүтэц байх тухай ярьж байгаа. Би бол буруу биш л гэж ойлгож байгаа. Гэтэл жинхэнэ өнөө газар нутаг дээрээ ажиллаж байгаа засаг захиргааныхаа нэгж дээр энэ чиглэлийн чинь хүн байхгүй болчихоор зэрэг хэдүүлээ яаж нөгөө тандалт судалгаа, мэдээлэл тэмцлийн ажил, юмнууд чинь явах билээ гээд эргэж бодмоор, хармаар юмнууд байна. Үүнийг хэлэлцэх эсэхийг нь дэмжчихсэн тохиолдолд хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг дээр нэлээн ярьж, асуудлыг нэлээн тийм цогц байдлаар хармаар байна. Хууль хоорондынх нь нийцлүүдийг нэлээн сайн хармаар байна. Хэдүүлээ энэ хуулийг батлаад Ургамал хамгааллын хуулиа хүчингүй болгоцхож байгаа шүү дээ.

Тэгэхээр тэнд яригдаж байсан зүйлүүдээс дутуу хараад орхигдчихож байгаа зүйл юу байгаа юм бэ гэдэг асуудал бас өөрөө байгаад байгаа байхгүй юу. Ийм юмнуудаа анзаарна биз. Би ажлын хэсгийнхнийг тэгж анхаарах ёстой гэж ингээ ойлгож байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Одоо Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Та дэмжчихээд хэлэлцүүлгийн үед ярья гэсэн биз дээ. Би таныхаар л яваад байна шүү дээ.

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Наранбаатар гишүүн танилцуулах уу? Наранбаатар гишүүн танилцуулъя. Ажлын хэсгийн хамт олонд баярлалаа. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалд орёе.



**Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Засгийн газрын мэдээллийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар сонссонтой холбогдуулан зохион байгуулж буй ажил, түүний явц байдлын талаарх мэдээллийг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Амарсайхан сайд танилцуулна.**

Амарсайхан сайдыг мэдээллээ хийхийг урьж байна.

**С.Амарсайхан:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хөдөө орон нутгийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх Засгийн газар Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцсэн өвөлжилтийн бэлтгэл ажил, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг үнэлэх хүрээнд Улсын онцгой комисс Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсэг Архангай аймаг, Завхан аймаг нийтдээ 11 сумаар ажиллалаа.

Өвөлжилтийн нөхцөл байдал бас өмнөх жилүүдтэй харьцуулах юм бол харьцангуй эрт хүндэрсэн. 11 дүгээр сарын 1-нээс эхлэн зудын нөхцөл байдалд орсноос үүдэн 11 аймгийн 40 гаруй сум, нийслэлийн алслагдсан дүүргүүдэд зудын тэр дундаа шилэн зуд гэдэг зүйл нүүрлэж байгаа. Малчдын өмнө тулгамдсан энэ асуудал бол зөвхөн хөдөө орон нутагт байгаа малчид, тариаланчдын асуудал биш. Энэ нийт Монголчууд бидний амьжиргаа, хүнс, хангалт, нийлүүлэлт, тэгээд хүнсний аюулгүй байдалтай шууд холбоотой нэгдүгээрт.

Хоёрдугаарт, эдийн засгийн гол салбар болсон энэ хөдөө аж ахуйн салбарын хувь заяатай холбоотой.

Гуравдугаарт бол малчид маань энэ хүнд цаг үед амаргүй сорилтыг давахын тулд өөрсдийнхөө нөөц бололцоог бүгдийг нь ашиглаж байна. Харамсалтай нь хураасан, нөөцөлсөн өвс тэжээлийн нөөц барагдаж байна.

Яагаад гэвэл мал бэлчих боломжгүй, зам хаагдсан, бэлчээр дарагдсан, эрт бороо орж, нойтон цас өнгөн хэсгийг бүрхсэнээс болж мөстсөн, дахиад цас орсон. Ингээд зөөлөн цаснууд дахиж дагтаршиж мал, машин битгий хэл машин явах ч аргагүй ийм нөхцөлд орсон байгаа. Малчид маань бол мал сүргээ өсгөхийн зэрэгцээ хажуугаар нь амьдрал ахуйгаа авч явж байна. Ажлын байрыг бий болгож байгаа, улс орноо хүн ардаа хүнсний зүйлээр хангаж байгаа, алс хязгаар нутагтаа бас эзэн сууж, дээрээс нь төр ард түмнийхээ өмнөөс харж, хандаж байгаа ийм хүмүүс. Өв соёлоо тээж байгаа.

Тийм учраас Засгийн газар, Улсын Их Хурлын онцгой анхаарал хандуулж шаардлагатай арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлж байгаа. Энэ жил улсын хэмжээнд нийт 190.1 мянган малчин өрхөд 69.1 сая хонин толгойд шилжүүлснээр 123 сая толгой мал өвөлжиж байгаа гэсэн урьдчилсан дүн гарсан. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 18.8 мянган малчин өрхийн 7.8 сая мал отроор өвөлжиж, хаваржих ийм зохион байгуулалт хийгдсэн ч цас их орсны улмаас отор нүүдлийн тоо нэмэгдэж байна. Бэлчээр улам хомсдож байгаа, аймгийн мэдээллээр 17.2 сая толгой малыг 5.1 сая толгой малыг нь хүнсэнд 12.1 сая толгой малыг зах зээлд нийлүүлэхээр хэрэгцээлэхээр судалгаа ирүүлсэн. Нийт малын 21.5 хувьтай тэнцүү байна. Энэ нь 23 онд бойжуулсан төлийн 95.5 хувьтай тэнцэнэ гэсэн дүн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр Монгол орны нийт нутгийн 81 хувьд цасан бүрхүүл тогтсон. Цаашид хүйтний эрч улам чангарна. Их хэмжээний цас орох, хүчтэй цасан шуурга шуурах, цасны өнгөн хэсэг хайлмагтаж мөсөн бүрхүүл тогтох зэргээр 23-24 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал улам хүндрэх төлөвтэй байна. Ер нь бол асар хүндэрсэн байна. Зудын эрсдэлийн зургаар нийт нутгийн 70 орчим хувьд их



буюу нэн их ийм эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан. Дөнгөж 26 хувьд нь дунд гэж байгаа юм.

Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу зудын байдалд үнэлгээ хийхэд 23 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар түрүүн ярьсан 11 аймгийн 40 гаруй сум цагаан зудтай, 12 аймгийн 48 сум цагаан зудтай гэхээр үндсэндээ бүх аймаг орон нутаг зудын нөхцөлд байна гэж хэлж болно.

Манай орны нийт нутгаар 11 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 8-ны өдрийг хүртэл нийт 4 удаагийн цаг агаарын аюулт үзэгдэл болсон. Цахилгаан дамжуулах шугам сүлжээнүүд унасан, мал сүрэг олноор хорогдсон, малчид эрдэнэт хүний амь нас хүртэл олноор эрсэдсэн харамсалтай үйл явдлууд болсон. Олон зуугаараа иргэд бас цаг шуурганд туугдах, төөрөх, сураггүй болох ийм хүндрэлүүд бий болж байгаа. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдон цаг их орсон аймгуудад, малчдад малаа ангилж ялгах, мөн шаардлагатай хэрэгцээнд нөөцлөх ийм ажлуудыг уриалгыг гаргасан. Орон даяар бас малчдадаа бид дэмжиж туслах аян уриалгыг олон нийтэд хандаж хүргэж байгаа.

Яагаад гэвэл энэ бас зөвхөн Засгийн газар малчид хоорондоо асуудлуудаа шийдээд цэгцэрчих зүйл биш гэдгийг хэлж байгаа нь тэр. Аймаг, сумдад жилийн эцсийн мал тооллого үндсэндээ явагдаж дүн нь нэгтгэж байгаа. Тэгэхдээ мал тооллого дээр анхаарах зүйлүүд байна. Бодитой тоолж байгаа нь ч байна, утсаар тоо авч байгаа нь ч байна. Энэ дунд малын үнэн бодит өсөлт тоон дээр бас асуудлууд байж болохгүй гэж үзэж байгаа учраас нягтлах ажлууд цаашид хийгдэх ёстой.

Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг та бүхэнд товчхон танилцуулъя.

Энэ 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар орон нутаг руу шатахууны нийлүүлэлтүүдийг нэмэгдүүлэх хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, малчдын бэлтгэсэн махыг мах зээл зах зээлийн хэрэгцээнд оруулах, малын тэжээлийн нийлүүлэлтийг тогтворжуулж нэмэгдүүлэх, эрүүл мэндийн болон бусад тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, малын хөлийн гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн үйлчилгээг малчид, иргэдэд илүү ойртуулах, мэргэжлийн түвшинд зохион байгуулах үүрэг чиглэлийг салбарын яамдад өгч, хэрэгжилтийг хангаж, бас хяналт тавьж, гүйцэтгэлийг дүгнэж ажиллаж байна.

Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан 21 аймаг, нийслэлийн алслагдсан дүүргийн малчид мал бүхий иргэдэд улсын нөөцөөс 4015 тонн хивэг, 1274 тонн хорголжин тэжээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр өөрөөр хэлбэл 50 хувийг хямдруулан олгох асуудлыг Засгийн газрын 23 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. Олгох асуудлыг аймаг сумдын Онцгой комисст хуваарилж, тэндээс зохион байгуулж ажиллаж байгаа. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 23 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар 82 мянган тонн хүнсний улаан буудай импортлох зөвшөөрлийг олгосон. Цаашид гурилын үйлдвэрүүдийн хэвийн тогтвортой үйлдвэрлэл явагдах ийм боломж бүрдэж байна гэж харж байгаа. Ингэснээр хивэг тэжээлийн нийлүүлэлт тогтворжих боломжтой.

Өвсний экспортыг 23 оны 9 дүгээр сард, тэжээлийн экспортыг 12 дугаар сард 23 оны 3 дугаар сар хүртэл хориглосон байгаа 24 оны. Улсын хэмжээнд өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан мах бэлтгэх аж ахуйн нэгжид 100 орчим тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг олгохоор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж

ишийдвэрлэсэн. Хөдөө аж ахуйн яам үүнийг зохион байгуулж байгаа. Малчид малаа бас ихээр бойлсон, зээлсэн байна. Гэхдээ худалдан авалт хангалтгүй байна. Малаа, махаа хэнд өгөх вэ гээд бойлчихсон, гаднаа овоолчихсон. Өгөх гэхээр өртөг бага, тээвэрлээд хүргээ гэхээр зардал өндөр, өөрсдөө хадгалъя гэхээр хадгалах сав, суулга бага гэх мэтийн ийм хүндрэлтэй, бэрхшээлтэй асуудлууд байгаа.

Тийм учраас Улсын онцгой комиссоос Хөдөө аж ахуйн яаманд аймаг, орон нутагтайгаа хамтраад сум, багийн хэмжээнд, аймгийн хэмжээнд бүсчилсэн маягаар явуулын худалдан авах цэгүүдийг энэ мал мах худалдан авдаг, боловсруулдаг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй хамтарч зохион байгуулах, шаардлагатай бол дахин Улсын онцгой комиссоос тээвэр болон бусад шатахууны дэмжлэгийг үзүүлэх гэх мэтээр ингэж малчдынхаа бид нөхцөл байдлыг ойлгож бас нэлээн тийм уялдаа холбоотой, дорвитой арга хэмжээ авахгүй бол ингээд мах, мал нь борлогдохгүй байх юм бол хавар ойртох тусам бүр хүндрэлтэй нөхцөл байдал руу орно, махны чанар алдагдана. Ингээд мах нийлүүлэх асуудал гэхдээ түүнийг худалдах авах асуудал бас амаргүй байгаа. Мах экспортлож байгаа компаниуд санхүүжилт бас дутагдалтай байна гэж байгаа гэх мэтийн ийм хүндрэлтэй нөхцөл байдлууд бас байна. Хөдөө аж ахуйн яамнаас энэ чиглэлээр тодорхой мэдээллүүдийг бас нэмж өгөх байх. Улсын онцгой комиссын даргын 23 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 8 дугаар тушаалаар Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Цахим хөгжил харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яам, Зэвсэгт хүчин Жанжны штаб, Хил хамгаалах ерөнхий газар. Гаалийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, тэгээд Ашигт малтмал, газрын тосны газар, Цааш уур, орчны

шинжилгээний газар, Мал эмнэлгийн ерөнхий газрын төлөөллөөс бүрдсэн Улсын онцгой комиссын Шуурхай штабыг байгуулан ажиллаж байгаа. Аймаг, орон нутагт хүртэл 24 цагийн ажиллагаатай Шуурхай штаб бүрэлдэхүүнээрээ ажиллаж байна.

Засгийн газарт танилцуулснаар Засгийн газрын Улсын онцгой комиссын ишийдвэрээр орон даяар энэ өвөлжилтийг өнтэй давах, хохирол багатай даван туулахтай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдалд орон даяар шилжсэн байгаа. Энэ жилийн цас зуд бол сүүлийн бас 10, 20 жил малчдад, хөдөө орон нутагт тохиолдоогүй ийм зуд зурхан болж байна. Цаг уурын өөрчлөлт уур амьсгалын хүндрэлээс шалтгаалсан иймэрхүү хүндрэл нөхцөлүүд цаашаа улам нэмэгдэнэ.

Тэгэхээр энэ салбар дундын зохицуулалтыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд бас холбогдох яамнууд ажлын уялдаа холбоогоо хангаж, хамгийн гол нь ажлыг эзэнжүүлж гүйцэтгэлийг нь хангуулж, үр дүнг нь тооцож, тэгээд зохион байгуулалтаа сайжруулах ийм шаардлага байгаа.

Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Сүхбаатар, Архангай, Завхан аймгуудад ажилласан. Ажиллагааны удирдлагын газрын даргаар ахлуулсан хэсэг Төв аймагт тус тус ажиллаж холбогдох асуудлуудыг тухай бүр газар дээр нь ишийдвэрлэж байгаа.

Гэхдээ бид хүндрэл, эрсдэл бий болчихсоны дараа биш, болохоос нь өмнө урьдчилан сэргийлж, эрсдэлийг багасгаж ингэж шат шатдаа анхаарч ажиллах шаардлага байгаа. Өвөлжилт хүндэрч, цас их орсон сумдад эрүүл мэндийн болон бусад төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, цаг уурын аюулт болон гамшигт үзэгдлийн үед эрэн хайх, аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах зэрэг шаардлагыг тус тус харгалзан үзэж Төв аймгийн Эрдэнэцогт сумын,

Архангай аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төв, Завхан аймгийн сумын Эрүүл мэндийн төв, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум дахь Гал түймэр унтраах, аврах анги, Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Онцгой байдлын хэлтэс, Завхан аймгийн Хасагт сумын Засаг даргын газар тус бүр автомашинуудыг шийдвэрлэж байгаа.

Аймаг, сумдад одоо нэг асуудал байна. Манай Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүд бас энэ дээр анхаарч ойрын хугацаанд Улсын Их Хурлаар энэ Хэмнэлтийн хуулийг өөрчлөх тухай асуудлыг нэн яаралтай оруулж шийдвэрлэхгүй бол өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 57 сум автомашингүй байна. Урсгал зардлаа хэдийгээр хөрөнгө нь байгаа ч гэсэн зарцуулж чадахгүй байна. Бензин тос шатахуундаа.

Яагаад гэвэл Хэмнэлтийн хууль гэдэг зүйлээр хориглоод хаячихсан учраас сум, аймгийн хэмжээнд төсвөө өөрсдөө зарцуулж, энэ орон нутгийн хэмжээний асуудлуудаа шийдвэрлэх нь хориотой байгаад байна. Тийм учраас Засгийн газар, Улсын онцгой комисс сонгогдсон гишүүдээсээ машин тэрэг авах, нэхэх гээд цаг хугацаа алдах, өөрсдөө эрх, үүргийнхээ хүрээнд хөрөнгө мөнгөө зарцуулах боломжгүй гэх мэтийн асуудал байгаа учраас энэ асуудлыг анхаарахгүй бол урсгал зардлыг нь хүртэл хаачихсан. Зарим лабораториуд урвалж бодисоо хүртэл авч чадахгүй болчихсон ийм байдалтай байгаа. Эдийн засгийн хүнд үед КОВИД-ын уршгийг арилгахын тулд Хэмнэлтийн хууль гэж баталсан нь тухайн цаг үедээ зөв байсан.

Гэхдээ Хэмнэлтийн хууль нэрээр улам эрсдэлээ нэмэгдүүлж, хохирлын өөрсдөө харсаар байж бий болгодог ийм нөхцөл байдлыг өөрчлөх ёстой гэж үзэж байгаа. Ирэх долоо хоногт, энэ долоо хоногтоо багтаж Улсын Их Хуралд энэ Хэмнэлтийн хуулийн өөрчлөлтийг өргөн барина. Та бүхэн маань бас дэмжиж, энэ асуудлыг шийдвэрлэх нь чухал байна шүү гэдгийг хэлье.

Төв, Архангай, Завхан аймгийн онцгой комиссын үйл ажиллагаанд шаардлагатай 60 тонн шатахууныг шийдвэрлэж өгсөн. Хөдөө орон нутагт шатахууны бас хангалт, нийлүүлэлт сайнгүй байна. Ялангуяа алслагдсан сумууд. Гэхдээ жигдэрч байгаа байх. Ашигт малтмал, газрын тосны хэрэглэх газар, Улсын онцгой комисс аймаг орон нутгийн шуудхан штабаар дамжуулаад сум, аймгаар нь зохицуулалтыг хийх, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байгаа. Завхан аймгийн Арц суурь боомтоор малын тэжээл, гурил, шатахуун импортлох асуудлыг яаралтай шийдвэрлэх.

Тэгэхдээ Завхан аймгийн, Завхан аймгийн Арц суурь биш ер нь энэ баруун аймгийн боомтуудаар орж ирж байгаа бусад Боршоо болон энэ Булган боомтоор орж ирж байгаа. Гэхдээ энэ дээр татвар өндөр байна, 25 хувийн татвар төлж байна гэж байгаа юм.

Тэгэхээр энэ татварын хөнгөлөлтийг нь баруун аймгуудаар орж ирж байгаа энэ боомтууд дээр хөнгөлж чөлөөлөөд Улаанбаатарт 50 төгрөг байгаа юмыг тэнд аваачиж 150 төгрөгийн үнэтэй болгож малчдын хүндрэлтэй амьдралд, хүнд байгаа амьдралд улам дарамт болгох уу, эсвэл цаанаас нь 60 төгрөгөөр оруулж ирээд өөрсдөө зардал багатай амь амьжиргаагаа аваад явах уу гэдгийг бодохгүй бол зарим тохиолдолд үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж байна гээд үнэ нь дийлдэхгүй байгаа нь, байхгүй нь олдохгүй. Арай гэж олж авсан тээврийн зардал гээд хэд дахин өөрийн өртгөөсөө нэмэгддэг. Ингээд Улаанбаатарын төвөөс аваачсан гурил, будаа, зарим тэжээл бол 1 дахин, 2 дахин үнэтэй болж байна.

Гэтэл цаад боомтуудаасаа 100 хувь хямдхан орж ирэх боломж байна. Өнөөдөр Улаанбаатар хотод 35, 40 мянгаар зарагдаж байгаа тэжээл цаанаасаа 15 мянгаар орж ирж байна.

Улаанбаатар хотод 110 мянгаар, 20 мянгаар зарагдаж байгаа гурил тэндээс 70 мянгаар орж ирж байна, 60 мянгаар орж ирж байна.

Тэгэхээр энэ нөхцөл байдлыг бид тохируулгыг нь хийж энэ хил гаалийн асуудлуудаа цэгцлэхгүй бол болохгүй байна гэж байгаа учраас Гаалийн ерөнхий газарт шуурхай штабаас чиглэл хүргүүлсэн. Энэ дээр холбогдох яамнууд бас анхаарч яаралтай арга хэмжээ авах хэрэгтэй байна Сангийн яам, Хөдөө аж ахуйн яам, холбогдох байгууллагууд.

Бензин, шатахуунаа ч гэсэн хямдхан оруулаад ирэх боломжтой байна. Эрүүл мэндийн сайдын 23 оны А396 дугаар тушаалаар, мөн А403 дугаар тушаалаар нийт 14, 20 сумын Эрүүл мэндийн төв түргэн, тусламжийн автомашиныг шийдвэрлэсэн байна.

Энэ долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар бас эрүүл мэндийн автомашиныг боломжоор нь шийдвэрлэх асуудлыг оруулахаар Эрүүл мэндийн сайдтай ярьж байгаа. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний экспортын нэг цонхны системийг нэвтрүүлж, төрийн болон ТББ-ын ажлын уялдаа холбоог сайжруулах, гэрчилгээ авахад зарцуулдаг байсан 13 хоногийн хугацааг бууруулж, ажлын 8 цагт багтаах ийм ажил хийгдсэн байна. Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрхтэй аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлж, тус улсын Гаалийн ерөнхий газрын цахим системд адууны мах экспортлох, дулааны аргаар боловсруулах, мах экспортлох 4 үйлдвэрийг шинээр бүртгүүлсэн гэсэн ийм мэдээ байгаа.

Махны экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд өнөөдрийн байдлаар Хөдөө аж ахуйн яамнаас өгч байгаа мэдээллээр 7361 мянган тонн мах экспортлогдсон байна гэж байгаа. Тэгэхдээ энэ өсөх боломжтой. Экспортыг нэмэгдүүлснээр хөдөө орон

нутагт байгаа үнэгүүдээд байгаа тэр мах, түүхий эдийн асуудал байгаа. Малчдын хамгийн их хөндөж байгаа асуудал энэ арьс шир, түүхий эд, дайвар бүтээгдэхүүний үнэгүүдлийн асуудал байна. Шатахуун, дизель түлиний асуудлыг бас харьцангуй жигдэрч байгаа учраас асуудалгүй байх гэж бодож байгаа. Ингээд та бүхэндээ үндсэндээ товчхон мэдээлэл өгөхөд ийм байна. Өшөө тодруулах зүйл байвал хариулаад явъя. Баярлалаа.

**Ж.Батжаргал:** Амарсайхан сайдад баярлалаа. Мэдээлэл Улсын онцгой комисс дээрээ нэгтгэж зангидагдаад хийгдэж байгаа мэдээлэл. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тодруулж нэмэлт хийх мэдээлэл бий юү?

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Амарсайхан сайд Улсын онцгой комиссын дарга, Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн, Т.Баярхүү Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян дарга хошууч, генерал, Есөн- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Наранчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Өнөржаргал Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга, Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Хишигдалай Уул уурхайн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга, Бунд-Очир Эрүүл мэндийн яамны Яаралтай тусламж, гамшиг, биотерроризмын үеийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн. Өөр нэр дурдагдаагүй хүн байна уу? Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. Ажлын хэсгийн гишүүд ийм гишүүд хүрэлцэн ирсэн байна.



Мэдээлэлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Наранбаатар гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүн асуулт асууя.

**Б.Бейсен:** Энэ өвөлжилтийн нөхцөл байдалтай холбоотой Шадар сайдын мэдээлэлтэй танилцлаа. Бас баруун аймгуудаар ер нь байдал нэлээн хүндэрсэн, 9 сарын сүүлээр, 10 сарын эхээр нэлээн зузаан цас орсон, зарим газар 50 см хүртэл цас орсон. Одоо тэгээд л өвөлжсөөндөө бүр 10 сард орчихсон шүү дээ. Доод тал нь хайлаад 15, 20 см нь хайлаад мөстсөн, дахиад нэмээд цас орж байгаа ийм хүнд байдалтай. Өвөлжсөөндөө эрт орчхоод, бэлчээрээ дуусгачихсан байна. Одоо энэ тэжээлийн нөөц бэлдэх талаар түрүүн Үйлдвэрчний яамны мэдээлэл дээр 74.8 хувь гүйцэтгэлтэй байна гэсэн. Үлдсэн юугаа хэзээ гүйцээх юм? Баян-Өлгий аймгийн хувьд энэ юун дээр тэрбум 400 сая төгрөгийн тэжээлийн нөөц бүрдүүлэх юу тавьсан юм. Тендерийг одоо хүртэл зарлаагүй бүүр аймгийн Онцгой комиссын даргатай утсаар ярьсан уржигдар. Мөнгө байхгүй байна, 100 хэдэн сая төгрөгтэй өөр юм байхгүй гээд тэгж байна. Уг нь намар эрт бэлдэх ёстой байсан энэ бас хугацаа алдаж байна. Энэ талаар Онцгой комиссоос авч хэрэгжүүлэх арга байна уу, аймгуудтай ярьж байна уу ер нь Шадар сайд аа?

Нөгөө талаар энэ импортын тэжээл гурилын татварын асуудал байгаа. Гааль, үүнийг чөлөөлөх талаас ер нь Засгийн газарт орсон байна. Сая та бас дурдлаа. Ойролцоо юугаар чинь энэ 45-50, 60 мянга хоорондоо 1 шуудай гурил авах боломж байна ерөөсөө цаанаасаа хил дагуу, бас түлшээ ч авчрах боломжтой байна. Гэтэл хил гаалийнхан дээр хилийн юугаар гараад авчирч байгаа 1 шуудай гурилд нь хориг тавьчихсан. Ерөөсөө оруулахгүй тийм асуудал гаргачихсан байна. Энэ талаар мэдээлэл авсан уу, цаашидаа яаж шийдэх вэ? Эрүүл мэндийн яамныхан бас ирсэн байна. Хөдөөгийн малчдын эрүүл мэндийн

тусламж үйлчилгээний асуудал байж байна. Эм ханган нийлүүлэх байгууллагууд аймгуудын аптека, эрүүл мэндийн газруудтай ярьж байгаад энэ хөдөөгийн малчдад яаралтай тусламжийн эм, багц бэлдэх талаар баримталж байгаа бодлого байна уу?

Ер нь аймгийн төв оръё гэж улсын хэмжээнд үзүүлэх гээд явдаг, өвчтөнөө зөөвөрлөдөг. Гэтэл бензин, шатахуунтай холбоотой очиж чадахгүй ийм хүндрэлтэй асуудал байна. Ядахдаа өвчин намдаах, халуун бууруулах, антибиотик тийм ийм боолтын асуудлын юм бэлдээд өгөх талаар баримталж байгаа бодлого байна уу? Өлгийд бол Сагсай сум мэднэ Хурган нуур, Хотон нуур, Даян нуурын тийшээ тэнд бас баг байдаг, сургууль, эмнэлэг, цэцэрлэгтэй, цэргийн ангиуд байдаг. Энд Онцгой комиссын зүгээс туулах чадвар сайтай түргэний машин шийдэж өгөх боломж байна уу? Зам хүнд байна ер нь, явах боломжгүй битүү цастай. Дараа тодруулъя.

**Ж.Батжаргал:** Хариулья  
Амарсайхан сайд.

**С.Амарсайхан:** Гишүүний ярьж байгаа асуудал дээр яах вэ. Аймгууд дунджаар ер нь өвс тэжээлийн аюулгүй нөөцөө 75-80 хувьтай энэ жил бүрдүүлсэн байгаа. Гэхдээ түрүүн хэлснээр өвөл бас эрт хүндэрсэн учраас өвс, тэжээлийн нөөц ч хомсодсон, бэлчээр ч байхгүй болсон ийм нөхцөл байдалтай бий.

Гэхдээ дөнгөж сая аймгууд бас төсвөө баталсан. Энэ батлах үеэр нь ч бид бас тодорхой чиглэл даалгавар өгсөн. Аймгууд аюулгүй нөөцөө түргэн шуурхай нэмэгдүүл ээ, бүрдүүл ээ, сум, багийн хэмжээнд малчидтайгаа нягт хамтарч ажилла, зөвлөмж зөвлөгөөгөө хүргүүл, шаардлагатай дэмжлэг, тусалцааг үзүүл гэж. Яах вэ зарим аймгууд бас хоцорч дутуу сумууд бүрдүүлсэн асуудлууд байна. Тэгэхээр энэ бол аймгууд бас анхаарах ёстой. Улсын



нөөцөөс хямдралтай үнээр өвс, тэжээл нийлүүлэх ажил бол үргэлжлээд явна. Гэхдээ энэ хангалттай биш.

Тэгэхээр бид хоёр арга хэмжээг ав гэж байгаа, малчдадаа уриалж байгаа.

Нэгдүгээрт, энэ байгаа өвс, тэжээлээ аль болох аймгийнх нь хэмжээнд малчдадаа нэмэгдүүлж хүргэ.

Хоёрдугаарт, малчид маань мал сүргээ ангилж ялгаад, онд орохыг нь авч үлдээд, болохгүйг нь тарга тэвээр алдахаас өмнө бойлж, хэрэгцээлж эдийн засгийн эргэлтэд оруулаач гэдэг.

Гуравдугаарт нь энэ түргэн тусламжийн автомашины асуудал байгаа. Одоо иууд Улсын онцгой комиссоос шийдээд байх тийм боломж байхгүй байгаа. Улсын нөөцөд цөөхөн хэдэн автомашин байдаг байсан, одоо тэгээд үндсэндээ шаардлагатай газруудад нь өгөөд дуусаж байгаа.

Тийм учраас би энэ Хэмнэлтийн хуулийг яаралтай Улсын Их Хурлын чуулганаар яаралтай горимоор оруулж, өөрчилж энэ аймаг, сумын удирдлагуудад хөрөнгө нь байхгүй биш байна, тэр эрхийг нь нээж өгч, автомашинаа хэрэгцээгээ хангах боломжийг нь бүрдүүлэхгүй бол болохгүй байна гээд. Ер нь цаашидаа бол хоёр зүйл дээр бид анхаарах ёстой. Яг энэ өвөлжилт, хаваржилттай холбоотой асуудлыг аймаг, сумын түвшинд, орон нутгийн түвшинд бие дааж өөрсдөө шийдвэрлэдэг байх ийм тогтолцоо руу орохгүй бол жил болгон өвөлжилт хүндэрлээ, өвс, тэжээл гэдэг яриа ярьсаар байгаад бид хэдэн арван жилийг үдлээ. Одоо дахиад хэдэн 10 жил ингэж явах боломж байхгүй.

Тэгэхээр энэ 21 аймаг цаашилаад энэ Улсын Их Хурлын сонгуулиар бүслээд явах юм бол бүс хоорондоо энэ мал аж ахуй, хөдөө аж ахуй бэлчээрийн менежмент, нөхөн сэргээх үйл ажиллагаа, ургамал хамгаалал, энэ

гамшиг эрсдэлийг тооцох, удирдлагын менежментээрээ хоорондоо уралддаг, өрсөлддөг тэр хэмжээгээр нь улсын нөөцөөс улсын төсвөөс бас хөрөнгө мөнгийг нь санхүүжилтийг нь шийдвэрлэдэг байх ийм боломжийг бүрдүүлэхийн тулд ажиллахгүй бол яг үндсэндээ энэ ургамал, бэлчээрийн нөхөн сэргээлт ч огт хийгдэхгүй байна. Энэ чиглэлийн байгаль орчноо сэргээх энэ бэлчээрээ хамгаалах л ажлын цогц бодлого ч байхгүй байна, малчдад орон нутагт гарц, гаргалгааг нь гаргаад, зөвлөмж зөвлөгөөг нь өгөөд загварыг нь бий болгоод өгвөл өөрсдөө хийх бүрэн боломж байна. Ийм нэгдсэн удирдлага шаардлагатай байна. Энэ дээр бас тодорхой тийм дорвитой ажлуудыг хийж байж бид цааш нь гарахгүй бол жил болгон ийм юмнууд угаасаа тасрахгүй.

Гэхдээ тасрахгүй байна, ийм байна гээд хаях эрх бидэнд байхгүй. Мал бол эх орны баялаг, малчид бол бидний нэг хэсэг, малчдын асуудал Монголын асуудал, малчдын эрсдэл бидний нийт Монголчуудын хувь заяа, амь амьжиргаатай холбоотой асуудал. Тийм учраас энэ дээр хүссэн, хүсээгүй Засгийн газар, Улсын Их Хурал анхаарахаас өөр арга байхгүй ийм нөхцөл байдалд байгаа. Тэгээд тэр гурил тэжээлтэй холбоотой асуудлыг би түрүүн хэлсэн. Энэ баруун аймгуудын хил гаалиар ор.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Амарсайхан сайдын микрофоныг сунгаад өгчихье. Гүйцээгээд хариулчихъя.

**С.Амарсайхан:** Баруун аймгийн энэ боомтуудаар орж ирж байгаа, орж ирж байгаа тэр гурил, тэжээл, бусад бүтээгдэхүүнийх нь татвар өндөр байгаа тэр асуудлыг бууруулж энэ зах зээлийн тохиргоо, хэрэгцээг хангах ажлуудаа Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, холбогдох яамнууд авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Дээрээс нь нэмээд тэр Завханы Арц сууриар орж ирэх зөвшөөрлийг нь олгож тэр хил гаалиар импортлох юм бол ядаж нэг аймаг ч гэсэн хэрэгцээгээ хямдханаар хангачих ийм боломж, нөхцөл байна тэжээл. Үүнийг Хил хамгаалах ерөнхий газар, гаалийн холбогдох газруудад бид бас үүрэг чиглэлийг нь хүргүүлсэн. Шаардлагатай бол Засгийн газрын хуралдаанаар оруулж шийдвэрлэнэ гэж байгаа юм.

**Ж.Батжаргал:** Эрүүл мэндийн асуудал дээр Эрүүл мэндийн яамны төлөөлөл хариулъя. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон дээр. Ажлын хэсгийн 1.

**А.Өнөржаргал:** Эрүүл мэндийн яам Өнөржаргал, Бейсен гишүүний асуултад хариулъя. Манайх 11 сард бүх эрүүл мэндийн байгууллагууддаа өвөлжилтийн бэлэн байдлыг хангах талаар албан даалгавар хүргүүлээд эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал, эм тарианы бэлэн байдал отор нүүдлээр явж байгаа бүх иргэдийн эрүүл мэндийн асуудлыг онцгой анхаарах гэсэн ийм чиглэл өгсөн.

Өнөөдрийн байдлаар бол сумын Эрүүл мэндийн төвүүд ер нь эм, тарианы нөөц манайд 1 сараас бүтэн жилийн ийм нөөцтэй байгаа. Эдгээр эм тарианаасаа малчдад энэ яаралтай энэ эм, тариаг хүргэх ажлыг сумын Эрүүл мэндийн төвүүд багийн бага эмчээр дамжуулаад зохион байгуулж байгаа. Мөн Эрүүл мэндийн яамнаас энэ отор нүүдлээр явж байгаа бүх жирэмсэн эхчүүд, зарим архаг хууч өвчтэй мөн 0-5 насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сумын Эрүүл мэндийн төвд татаж авчрах энэ арга хэмжээг зохион байгуул гэсэн ийм үүрэг чиглэл өгсөн. Үүн дотроос хамгийн чухал нь нөгөө төрөх дөхсөн эхчүүдийг бүгдээрэнг нь сумын эхийн амрах байранд авчирч аюулгүй байдлыг нь ханга гэдэг ийм чиглэл өгсөн байгаа.

Мөн олон улсын дэмжлэгтэйгээр энэ яаралтай тусламж байгууллагуудын дэмжлэгтэйгээр яаралтай тусламжийн

багцыг бас өгөхөөр өнөөдөр холбогдох арга хэмжээг аваад энэ олон улсын байгууллагууд руугаа хандаж байгаа.

**Ж.Батжаргал:** Бейсен гишүүн тодруулъя.

**Б.Бейсен:** Энэ түрүүн би Шадар сайд, Хөдөө аж ахуйн сайд, Байнгын хорооны даргад бас санал хүргүүлсэн. Булган аймгийн 10 суурь мал Ховд аймгийн тэр Ховд сумын нутагт Хөх сэрхийн нуруунд оторлон бэлчсэн 10 суурь мал байгаа. Гэтэл эд нарыг чинь 3 сая төгрөгөөр торгоод буц гээд байгаа юм. Ер нь Байгаль орчны сайд шүүхээр зар... гэж байгаа байхгүй юу. Одоо шүүхээр зар.. юм уу, оторт байх юм уу, мал нь буцах ямар ч бэлчээр байхгүй. Энэ асуудлыг шийдэж өгөөч та бүхэн.

Хоёрдугаарт, энэ сая эрүүл мэндийн юм ярьж байна энийг ер нь яамнаас аймгууд руу очоод, аймгаас сумууд руу очоод шалгахгүй ер нь эм дутагдалтай байна. Би яваад, үзээд ирлээ эм байхгүй, үнэтэй байна ерөөсөө. Энэ дээр хяналт, шалгалт хийхгүй бол болохгүй шүү нөхдүүд.

**Ж.Батжаргал:** Санал байна. Ганболд гишүүн асуулт асууя.

**Г.Ганболд:** Би энэ дээр энэ Байнгын хорооноос тогтоол гарах гэж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Би энэ тогтоол дээр уг нь санал хэлсэн юм засаагүй л юм шиг байна эртээр. Гурил, тэжээл, бас импортын татвартай холбоотой тэр 7 дахь заалт дээр саналууд хэлсэн. Үүнийг оруулаад явах нь зөв байх. Ер нь аймгууд нэлээн хүндэрчихлээ. Сая Хөдөө аж ахуйн сайд бас Өвөрхангайд очоод ирсэн. Өвөрхангай бас уг нь гайгүй байсан, сүүлийн үед маш их цас орж ер нь хүндэрчихлээ л дээ.

Тэгэхээр бид нар яаралтай арга хэмжээнүүдээ аваад явах хэрэгтэй байна Шадар сайд аа. Саяын таны хэлсэн тэр хил, гаалиар өвс, тэжээл орж ирэх

,тэжээл орж ирэх ийм шийдвэр гаргах юм бол яаралтай яаралтай Засгийн хурлаар орвол ороод, хууль өргөн баривал бариад шийдэхгүй бол бид нар ярьсаар байгаад хугацаа нэлээн алддаг. Одоо бол яг өвөлжилт хүндэрч байгаа үед бол 12, 1 сард л арга хэмжээнүүд авахаар бол маш хурдтай авчих ийм зайлиггүй шаардлага байдаг юм.

Тэгэхгүй манайх чинь явж байгаад бүүр хавар хүндэрсэн хойно нь арга хэмжээ аваад ямар ч үр дүн байхгүй. Одоо жоохон өвс, тэжээл байгаа бол зүгээр бушуухан шиг аймгуудад нь хуваарилаад, тараагаад хөнгөлөлттэй өгдөг бол одоо л өгчихмөөр байгаа юм. Энэ хүрээнд Шадар сайд аа Өвөрхангай руу ямархуу хэмжээний саяын аймгууд үзүүлж байсан шиг ийм тэжээлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох ийм боломж хэр байгаа вэ. Энэ дээр бас дэмжлэг үзүүлбэл бид нар энэ тээвэрлэлтийн асуудлыг нь шийдээд, энэ аймаг орон нутгийн удирдлагуудтай ярьж байгаад эртхэн шиг тарааж өгөх ийм зайлиггүй шаардлага байна. Тэгээд энэ дээр та тодорхой хариулт өгөөч ээ.

Ер нь одоо хөдөөгийнхний хувьд хамгийн тулгамдаж байгаа асуудал нь тэжээлийн үнэ нэлээн өндөр байна. 30 мянга болчихсон буухгүй байна. Үүнтэй холбоотой Засгийн газраас энэ тэжээлийг гадагш нь экспортлохыг 3 сар хүртэл хориглосон гэж ингэж ойлгоод байгаа. Энэ хугацааг бас дахиад жаахан сунгах хэрэгтэй байгаа юм. 3 сар хүртэл энэ тэжээлийн үйлдвэрүүд чинь складандаа байлгаж байгаад л 3 сар болохоор нь урагш нь гаргаад л явуулчихна шүү дээ. Дотоодын зах зээл дээр зарахгүй.

Тэгэхээр зэрэг энийг бас нэлээн тодорхойгүй хугацаагаар хязгаарлах ийм шийдвэрийг яаралтай гаргах хэрэгтэй байна. Тэгж байж энэ дотоодод байгаа энэ тэжээлийн үнийг жоохон бууруулахгүй бол гадагш нь гаргахаар чинь тэгээд яаж бид нар энэ үнийг нь

барих вэ? Энэ дээр бас яаралтай арга хэмжээ аваадхаач. Ойрын үед тийм боломж байгаа юу гэдэг хоёр зүйл л асууя даа.

**Ж.Батжаргал:** Хариулъя  
Амарсайхан сайд.

**С.Амарсайхан:** Ганболд гишүүний асуусан энэ гурил, тэжээлийн гаалийн албан татварыг багасгах, бууруулах, ялангуяа энэ баруун боомтуудаар энэ асуудлыг нэн даруй авч хэрэгжүүлнэ. Сангийн сайдад бас энэ талаар саналууд очсон байгаа, Хөдөө аж ахуйн сайд ч гэсэн ерөнхийдөө санал нэг байгаа гэж ойлгож байгаа.

Хоёрдугаарт, энэ арга хэмжээг яаралтай авах хэрэгтэй гэж байгаатай санал нэг байгаа. Улсын онцгой комисс 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрөөс эхлээд л ер нь бол өвөлжилт хүндэрнэ, бэлтгэл ажлаа сайтар ханга, зохих арга хэмжээнүүдээ авч, уялдаа холбоогоо, салбар хоорондын уялдаа холбоог ханга гэдэг ийм асуудлыг аймаг, орон нутгийн удирдлагууд, мэргэжлийн байгууллага, салбарын яамнуудад байнга хүргүүлж бас хэрэгжилтэд хяналт тавьж ирсэн. Зарим арга хэмжээнүүдийг бас харьцангуй эрт авч хэрэгжүүлж байгаа. Ялангуяа саяын улсын нөөцөд байгаа энэ тэжээлийг бид заавал хавар хүртэл хүлээгээд, мал суучихсан, тарга тэвээр алдчихсан, нэмэргүй болчихсон хойно мянга өгөөд нэмэр байхгүй учраас сая ийм шийдвэр гаргаад өнгөрсөн долоо хоногоос эхлээд аймаг, сумуудад хуваарилаад өгч байгаа, эхэлж байгаа.

Тийм учраас энэ хүрээнд Өвөрхангай аймагт бас хуваарилагдаж байгаа энэ тэжээлүүд ойрын хугацаанд ер нь бол хүргэгдэж байгаа. Аль аль сумууд хүндэрч байна гэдэг эрэмбэ зэрэглэлийг нь гаргаад тэрний дагуу хүргэгдэнэ. Тэгэхдээ энэ ажил нэг хийгдээд дуусахгүй цаашаа үргэлжлээд нөхөн хангалтаа хийгээд яваад байх юм. Үүний хажуугаар бас нэг арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа. Бид

Улаанбаатар хотод гурил, тэжээл энэ хужир шүү, дээрээс нь эрдэст бодис, уураг үйлдвэрлэдэг энэ аж ахуйн нэгжүүдтэй уулзалдаад яг үйлдвэрийн үнээр нь аймаг, сумдад нийлүүлэх ийм арга хэмжээнүүд зохион байгуулалт руу орж байгаа.

Тэгэхээр одоо бол аймаг, орон нутгийн удирдлагууд захиалгаа өгөөд аль сум аймагт хэчнээн тонн тэжээл, бордоо дээрээс нь энэ уураг, эрдсүүд хэрэгтэй гэж захиалгаа өгчихвөл шууд дундыг нь нэмэлт үнэгүйгээр үйлдвэрээс нь аймаг, орон нутагт хүргэхэд нь Онцгой комиссоор шуурхай итабаас дэмжлэг үзүүлж, зохион байгуулж байгаа. Энэ дээр бас Хөдөө аж ахуйн яам бид хамтраад ажиллаж байгаа учраас харьцангуй гайгүй цаашаа үргэлжлээд явчих байх.

**Ж.Батжаргал:** Болорчулуун сайд нэмэлт тодруулга өгье.

**Х.Болорчулуун:** Ганболд гишүүний асуултад хариулья. Энэ Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хуралдсан, 3 хоногийн өмнө Ерөнхий сайдаар ахлуулсан. Үүгээрээ бол баруун гурван аймаг Завхан ороод, баруун дөрвөн аймаг гэсэн үг. Бас гурил, тэжээлийн хувьд бол төвийн болон зүүн бүсээс 20 хувтай хэрэглэж байгаа энэ Цагааннуур, Боршоо, Арц суурь боомтоор гурил, тэжээл оруулах асуудлыг бол ярилцсан. Ингээд шийдвэрийг Гаалийн ерөнхий газар, бусад холбогдох газрууд руу өгч байгаа гээд хэлье. Энд бол тодорхой хэмжээний квот гаргасан байгаа гээд хэлье.

Одоо хамгийн гол нь энэ малчид бол энэ жил бол ойрын жилүүд болоогүй хүйтэн болж байна, мал уруудаж байна, ялангуяа бод мал, үхэр, адуу маш их уруудаж тэрийгээ дагаад хүмүүс машинтай дагаад нүүдлийн байдалтай ингэж явж байгаа.

Шатахуун, түлиний асуудал газар сайгүй хүндрэлтэй байна. Үүн дээр

л гол анхаарч үзээч гэдгийг бол явсан газар болгон хөдөө орон нутаг хэлж байна гэдгийг хэлье. Түли, шатахуунгүй болоод суухад хаана ч осгож мэдэх аюултай л даа. Тэрнээс биш тэжээл, өвс бол хоёрдугаар асуудал. Мэдээж тэр өвсийг бол улсын нөөцөөс өгөхөө больсон. Тэжээл ч гэсэн өглөө гэхэд 1 айл дээр тав, гурван шуудайнаас илүү очдоггүй. Тэр онц чухлаас илүү шатахуун чухал байна гэдгийг ярьж байна.

Хоёрдугаарт, Хэмнэлтийн хууль сая энэ талаар Шадар сайд ярилаа. Хэмнэлтийн хуулиар энэ бүх аймгийн хөдөө аж ахуйн удирдах газрын машингүй болгочихсон. Цас, зудын үед үнэхээр ажиллаж чадахгүй байна. Аймгийн дарга нар хэлж байна энэ манай Хөдөө аж ахуйн газрын дарга нар ажиллах ямар ч нөхцөлгүй, би хөдөө орон нутаг сумаар явуулах гээд байдаг, янз бүрийн ажиллах гээд байдаг.

Гэтэл машингүй, бензинийх нь зардал гэсэн чинь жилийн 360 мянга. Улаанбаатар яваад ирэх мөнгө шүү дээ. Энэ байдал бол Хэмнэлтийн хууль гэдгээрээ бол яг онц чухал хөдөө орон нутгийн ийм цас зудтай тэмцэж ажиллаж байгаа энэ газруудын ажиллах гарыг мухарласан шүү. Бүх газрын дарга нарын машиныг байхгүй болгоно гэсэн нэрээр тэр Улаанбаатарын яам, тамгын газрын дарга машин унахгүй л байдаг юм байгаа биз. Хүнс, хөдөө аж ахуйн удирдах газар аймгуудын энийг машинтай болгох, бензин, шатахууныг нэмэгдүүлэх тал дээр бол бас тусгайлан Хэмнэлтийн хуульд өөрчлөлт оруулж шаардлагатай байна шүү гэдгийг бас Шадар сайдад хэлье. Баярлалаа.

**Ж.Батжаргал:** Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

**Г.Тэмүүлэн:** Өвөлжилтийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулаад бас Байнгын хорооноос тогтоолыг гаргах гэж байна. Ерөнхий мэдээллийг сонссон. Би бас Амарсайхан Шадар сайд болоод Улсын онцгой комиссын даргын



хамтаар Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга Баярхүү болоод Онцгой байдлын ерөнхий газрын дарга Ариунбуян дарга нарын хамтаар бас Архангай аймагт хүндэрсэн сумууд дээр бол ажиллалаа. Сая өнгөрсөн 5 хоногийн хугацаанд бас 5 сум дээр очиж нөхцөл байдалтай нь бол үнэлэлт дүгнэлт өгч, хүндрэлтэй, бэрхшээлтэй асуудлууд дээр дэмжлэг, туслалцаа үзүүлэх, өвс, тэжээл нийлүүлэлт болоод бензин, түлшний зохицуулалтуудыг хийх ажлуудыг бас боломжийнхоо хүрээнд л Онцгой комисстой хамтраад хийсэн. Энэ дээр бид хэд анхаарах хоёр, гурван асуудлууд байна.

Нэгдүгээрт, мал махны явуулын худалдаа зохион байгуулах энэ шийдвэрийг бол Засгийн газраас гаргасан байгаа Засгийн газраас гаргасан. Тэгэхээр үүнтэй холбогдуулаад бид нарын хувьд бол би энэ тогтоолын төсөл дээр 1 зүйлийг нэмж хийх гээд байгаа юм. 3 дугаар зүйл дээр хөдөө орон нутагт бэлтгэгдсэн махны нөөцийг тогтоон борлуулалтыг дэмжих гэсэн ерөнхий зохицуулалт байгаад байгаа юм. Тэгэхээр ерөөсөө энд бол бид нар онцолж хэлэх ёстой зүйл бол өвөлжилтийн байдал хүндэрсэн сумдад мал, махны явуулын худалдан авалт хийх энэ зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай аваач л гэдэг асуудлыг хэлэх гээд байгаа юм.

Яагаад вэ гэхээр яагаад вэ гэхээр өвөлжилт хүнд хүндэрсэн энэ аймгууд дотроо онцгой хүнд байгаа сумдууд байна. Энэ сумдууд жишээ нь манай Архангай аймгийн Цахир, Хангай гээд сумд байдаг. 150, 200 мянган малтай малтай байсан чинь нийт малынх нь 50, 60 хувийг нь бол хөөрхий цас зуд ороод бүгдээр нь хэрэгцээлчихсэн байна. Хэрэгцээлчихсэн, бойлсон мал, мах нь бүгдээрээ ингээд хувь хүний гар дээр, айл өрхүүдээр нөөцлөгдсөн байгаад байдаг.

Тэгэхээр бид нар энэ хавраас өмнө, цагаан сараас өмнө эдгээр өвөлжилт хүндэрсэн сумууд дээр, зудтай

байгаа сумуудын энэ сандарч хэрэгцээлсэн бойжсон мал, махыг явуулын худалдан авалт хийх энэ зохион байгуулалтыг бүүр онцгойлж хийж, тусалж өгөөч. Тэгэхгүй бол ерөнхий байдлаар ингээд явдаг, улсын хэмжээнд зудтай, зудгүйгээрээ бас ялгавартайгаар хандахгүйгээр гарах вэ гэдэг асуудал байна.

Хоёрдугаарх нь хоёрдугаарх нь түлшний асуудалтай холбоотой. Түлш, шатахуун мэдээж энэ дээр бол Засгийн газраас онцгой анхаарч байгаа, тодорхой зохицуулалтуудыг хийж байгаа. Өвөлжилт хүндэрсэн сумууд дээр түлхүү нийлүүлэх асуудлуудаар анхаарч байгаа. Энд анхаарах асуудал бол зөвхөн нийлүүлэлтээс гадна үнийн асуудлууд бас үүсэж байна шүү. Орон нутгийн колонкууд дээр. Зуд болохоор нөгөө нохой зоолдог гэдэг шиг тухайн зарим орон нутгийн компаниуд ч гэдэг юм уу эд нар маань зарим байгаа цөөхөн хэмжээний дизель түлшнийхээ үнийг хамаагүй зургаа, долоон зуун мянган төгрөгөөр нэмэгдүүлэх ч гэдэг юм уу, мэдээж тэр тээвэрлэлтийн зардлууд үндэсний асуудлууд орсон байгаа. Тэгэхдээ хяналтын асуудлууд, шударга өрсөлдөөний асуудлууд бас энд яригдах гээд байна.

Гурав дахь асуудал нь отор, нүүдэл ихээр хийгдэж байгаа. Отор, нүүдэл хийгдэж байгаа сумууд дээр, малчид дээр болохоор хөөж туух асуудлууд их байгаад байдаг. Ингээд хүлээж авахгүй гэдэг, хураамж, хөлс авах асуудлууд яригддаг. Нэг айлыг буулгалаа гэхэд магадгүй айл болгон 2-5 сая төгрөгийн хөлс авдаг. Магадгүй юу гэдэг юм гайгүй өвөлжөөтэй байгаа аймгийн малчид нь хажуудаа 4, 5 айлыг авчихдаг. Гэтэл хөрш зэргэлдээ, айл саахалтынх нь айлууд нь ад үзэх асуудлууд үүсдэг.

Тэгэхээр энэ дээр бид нар зохицуулалт хийх шаардлагатай байна. Би тэр дундаа онцгой хэлэх гээд байгаа зүйл Засгийн газар энэ дээр Засгийн

газрын тогтоол гаргаад, 19 онд гаргаж байсан шигээ үүн дээр ерөөсөө ямар нэгэн отор, нүүдэл хийж байгаа малчдыг, оторчдыг хөөж туух, хүлээж авахгүй байх гэдэг асуудал байж болохгүй. Зохицуулалт, менежментийг зөв хийх, хураамж авахгүй байх гэдэг асуудлыг бүүр онцгойлж, үл ойлголцол үүсэхээс сэргийлэх энэ тогтоолыг бол гаргах шаардлагатай байна гэж хараад байгаа юм.

Дөрөвдүгээрт асуух асуулт нь арьс, ширний урамшуулал 2023 онд ороогүй. Жоохон тэжээл, хүнсээ авъя гэхээр нөгөөдөх энэ 23 оны урамшуулал яагаад орохгүй үүнийг асуугаач гэдэг зүйл асуугаад байгаа юм.

Хэрэгцээлсэн энэ мал, махны арьс ширний асуудлууд бас аягүй хүндрэх гээд байна. Хавар болохоор тэгээд л эрүүл ахуйн асуудлууд үүснэ. Энийг яах вэ гэдэг асуудал байгаа юм. Сүүлийн хоёр асуулт.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Цаг хүндэрч байгаагаар холбогдуулж, малчид бас нэлээн малаа хийх, бойлох ажил бол их байна. Тэгэхдээ энэ жилийн хувьд бол махан дээр бол өнгөрсөн жилийнхээс хамаагүй илүү төсөв хөрөнгө тавигдсан. Энэ бол зөвхөн нийслэл гэхэд 48, 49 тэрбум төгрөгийг компаниудтай гэрээ байгуулаад нөөцийн мах бэлтгэж байна. Мөн хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах 36 дугаар тогтоолын хүрээнд нийт 71 тэрбум махны үйлдвэрлэлд гарснаас 49, 50 тэрбум нь зүгээр мах худалдаж авах эргэлтийн хөрөнгөд гарсан.

Тэгэхээр нийт 100 тэрбумыг мах худалдаж авахад гараад байна. Дээрээс нь бас Засгийн газрын хуралдаанаар дахиж 100 тэрбумыг мах авахад ингээж зориулж гаргахаар шийдвэрлэсэн гэдгийг бас хэлье.

Гэхдээ энд бол улс махыг шууд авчих биш. Тийм боломжгүй, зах зээлийн дундуур нь ороод улс авна гэх боломжгүй. Тэр махны үйлдвэр, махны бизнес эрхэлдэг компаниуд ялангуяа тэр агуулгатай компаниудыг авхуулах арга хэмжээг бас хийх тал дээр манай яам ажиллаж байгаа.

Гэхдээ энэ дээр бол компани энэ тал дээр маш хойрго хандаж байгаа юм. Хойрго гэдэг нь бол дуртай биш гэсэн үг. Яагаад гэвэл нөөцийн мах бэлдсэний улмаас 2 жил дараалан олон компаниуд санхүүгийн хүндрэлд орсон байна. Нөгөө нөөцийн махыг бэлдүүлээд, тийм тийм дэлгүүрт худалдана, тэдэн сарын тэднээс хойш худалдана, үзэсгэлэн худалдаанд худалдана гээд нарийн заагаад өгчихдөг. Энэ яг нөгөө зах зээлийн жамаараа бэлтгэсэн махаа бэлтгэхэд хүндрэлтэй байдаг. Ингээд зун болоод ногоо гарчихад нөгөө мах нь байж байдаг. Үүнээсээ болоод олон компаниуд нөөцийн махнаас болж нэг ёсны төр оролцсоноос болж гэж асуудал үүссэн гэдгийг өчигдөрхөн хүртэл Өвөрхангай тэр агуулах нь хоосон мөртөө “Дэлхийн хүнс” гээд махны компани бид нөөцийн мах дахиж бэлдэхгүй. Харин бид аваад, эргээд борлуулж чадахгүй бол хохирлыг нь төр даана гэвэл авч болно. Тэрнээс биш нөөцийн мах бэлдэхгүй гэдэг асуудал ярьж байна.

Тэгэхээр хүчээр бас оролцох нь бол бас учир дутагдалтай шүү. Ер нь тэр болохгүй байна, энэ болохгүй гээд янз бүрийн хүндрэл бэрхшээл, зудтай үед яалаа гээд төр бас хүч дээр зах зээлийн хангалт, борлуулалтын дундуур оролцох, хэт оролцогч нь зах зээлийн үл үзэгдэгч гарыг ажиллах ажиллагааг нь байхгүй болгоод хаях сул талтай шүү гэдгийг бас хэлмээр байна.

**Ж.Батжаргал:** Тэмүүлэн гишүүн тодруулъя.

**Г.Тэмүүлэн:** Холбогдох албан тушаалтанд бас нэмээд тодруулга

мэдээлэл өгөөч. Би уг нь хоёр, гурван асуулт асуусан. Энэ арьс ширний 2023 оны урамиуулал яагаад орохгүй байгаад байгаа юм бэ, хэзээ орох юм бэ? Малчид бас өвс, тэжээл татах гээд хөрөнгө, мөнгө санхүү хүлээгээд байдаг. Нэгдүгээрх нь.

Хоёрдугаарх нь энэ өвлийн стандартын дизель түли чинь өөрөө -45-д зарцдаггүй дизель түли өөрөө хүнд байгаад байгаа юм. Тэгэхээр жишээ нь Архангай аймгийн хамгийн тэр өвөлжилт хүндэрсэн Завхантай, Хөвсгөлтэй хиллэдэг жишээ нь Цахир, Тариат, Хангай гээд тэнд байхгүй байгаад байгаа шалтгаан нь тэр болчхоод байгаа юм. Наад талын сумууд дээр байгаад байдаг -25-ынх, 45-ынх жишээ нь нийлүүлэлт хэр байгаа бол? Үүн дээр тайлбар, мэдээлэл өгөөч.

Гурав дахь нь Засгийн газар Би хэлээд байгаа зүйл энэ Засгийн газар отор, нүүдэл хийхтэй холбоотой тогтоолыг ирэх долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар гаргаж өгөөч. Тэгэхгүй бол хөөж туугаад, хөлс хураамж аваад, дураараа авирлаад нөгөө муу хэдийг чинь зовоогоод, хүндрэл бэрхшээл учруулаад байна гурав дахь нь.

Дөрөвдүгээр нь болохоор энэ мал, махны явуулын худалдаан дээр Засгийн газар зохицуулалт хийх ёстой байхгүй юу. Энэ чинь оролцож байгаа асуудал биш. Хүндэрчихсэн сумууд дээрээс.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Тодруулаад гүйцээгээд асуучих. Тэмүүлэн гишүүн тодруулаад, гүйцээгээд асуугаадах.

**Г.Тэмүүлэн:** Дөрөвдүгээр нь энэ өвөлжилт хүндэрсэн сумууд дээр бид нар ерөөсөө төр зохион байгуулалт хийж зохицуулалт хийе л гэдэг асуудал яриад байгаа юм. Тэрнээс бид нар зах зээлийн харилцаанд оролцоод байгаа асуудал биш байхгүй юу. Энэ бол төр нэгэнтээ байгаад байгаа бол, энэ чинь гамигийн байдал үүсчихсэн байгаад байгаа бол

тэнчээ юу гэдэг юм хагас метр шахуу цас орчихсон, дээрээс нь юу гэдэг юм ямар ч отор, нүүдэл хийх боломжгүй болчихсон, мал махаа борлуулах боломжгүй болчихсон энэ байдал дээр бол төрөөс үнэхээр энэ мал, махны явуулын худалдан авалтыг Засгийн газар хийж мөнгө төгрөг, санхүүжилтийг нь гаргаж байгаа бол энэ чинь онцгойлоод байгаа оносон газар дээр тэр мөнгө төгрөг, санхүүжилт нь хүрдэг, яг байгаа оносон тэр сумууд дээр эрсдэлийг нь бууруулдаг байх л зохицуулалт хийх ёстой болчхоод байгаа юм.

Тэгэхээр бид нар чиглэл өгч энэ худалдан авалт хийж байгаа, дамжуулж байгаа аж ахуйн нэгж тэр үйлдвэрүүд нь эндээс татан авалт хийх гэдэг юм уу, эсвэл аймаг, орон нутгууд нь ч гэсэн бид нар энэ дээр чинь тэр бензин, түлшнийх нь, шатахууных нь зардлыг нь гаргаад ч гэсэн тусалж болно шүү дээ. Ганцхан худалдан авалт хийх л чиглэлийг Засгийн газраас гаргаж өгөөч гээд байгаад байгаа юм. Энэ дөрвөн асуудлыг л.

Хариулья. Дөрвөн асуулт хэн хариулах юм? Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

**Ч.Хишигдалай:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Хишигдалай, хоёр дахь асуултад хариулья. Орон нутгийн хэрэглээ бага байдагтай холбоотой зарим алслагдсан сумдын улирлын түли гэж байдаг -25 градустай энэ түли дуусаагүй байгаа асуудал нэгдүгээрт байна.

Хоёрдугаарт Оросын Холбооны Улсаас нийлүүлж байсан шатахууны нийлүүлэлт нэлээн хоцролттой нийлүүлсэн. Үүнтэй холбоотой бас Улаанбаатар хотод нэлээдгүй түли нь улирлын чанартай түли байгаа. Бид өнгөрсөн долоо хоногт энэ өвөлжилтийн хүндрэлтэй холбоотой Монгол Улсын 21 аймаг, 360 сумтай холбогдож, Засаг

дарга нартай нь холбогдож түши, шатахууны хангалтын талаар мэдээлэл авч ажилласан. Үүнээс 344 сумын Засаг даргатай бол яг холбогдож мэдээлэл авсан.

Үүнтэй холбоотой “НИК” компани бол 361 сумын дийлэнхэд нь бол шатахуун түгээх станцтай байдаг.

**Ж.Батжаргал:** Гүйцээгээд хариулаадах 2 дугаар микрофон.

**Ч.Хишигдалай:** Та “НИК” компани бол өнгөрсөн 5 дахь өдрөөс эхлээд бүх орон нутгийг өвлийн түлшээр хангах компани ажлыг өрнүүлээд явж байгаа. Энэ долоо хоногийн 5 дахь өдөр гэхэд бүх салбараараа өвлийн дизель түлшийг шинэчилж нийлүүлнэ. Амлалтаа өгчихсөн байгаа, ажиллаж байгаа.

**Ж.Батжаргал:** Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

**Г.Наранчулуун:** Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Наранчулуун байна. Арьс ширний урамшууллыг энэ жил и-баримтаар дамжуулан шалгалтаар хийж байгаа учраас нэлээн удааширсан. Энэ ондоо багтаагаад олгох сайдын тушаал гарсан байгаа.

Хөөж туух асуудлыг Улсын онцгой комиссын хуралдааны 4 дүгээр тэмдэглэлээр аймгуудын Засаг дарга нарт энэ хөөж, туухгүй байх чиглэл, үүрэг чиглэлийг өгүүлсэн байгаа. Энэ Улсын онцгой комиссын шийдвэрийг хангаж ажиллана гэж бодож байгаа.

Мал, махны асуудал дээр Махны холбоотойгоо хамтраад хүндэрсэн сумдынхаа нэрсийг бид нар өгч байгаа. Аль үйлдвэрүүд нь энэ сумдад очиж мал худалдан авах талаар нь бол санал авч байна. Яг түрүүн бас сайд хэллээ махны үйлдвэрүүд бас тийм их уриалга хандахгүй байгаа.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Амарсайхан сайд.

**С.Амарсайхан:** Болорчулуун сайд бид нар бас яриад байгаа юм. Тэгээд энэ мах, мал худалдан авдаг аж ахуйн нэгжүүд, дулааны аргаар ялангуяа боловсруулдаг аж ахуйн нэгжүүдэд энэ хөнгөлөлттэй зээл хамрагдах боломж нь нээлттэй байгаа. Дээрээс нь аймаг, орон нутгийн төвүүд дээр худалдан авах цэгээ явуулын маягаар байгуулаад, шаардлагатай бол тэр дээр нь бас тодорхой тээврийн зардлыг нь хэмнэх үүднээс тээвэр шатахуун дээр нь тусалъя гэж байгаа юм.

Энэ ажил дээр манай Хөдөө аж ахуйн яамныхан маань өшөө сайн ажиллах хэрэгтэй байна. Улсын онцгой комисс шуурхай штаб дээр Ариунбуян дарга, Баярхүү дарга хоёр байж байгаа. Ингээд энэ аж ахуйн нэгжүүдтэйгээ өшөө сайн зохион байгуулалтад ороод ажиллахгүй бол тэгээд аж ахуйн нэгжүүд дурамжхан байгаа гээд бид бас урдаас нь нэг аж ахуйн нэгж дурамжхан байхаар бусад нь дурамжхан гэдэг юм руу орж болмооргүй байгаа юм. Энийгээ та хэд маань сайн анхаараад ажиллах хэрэгтэй. Сая бас Болороо сайд бид нар яриад үндсэндээ яасан. Хоёрдугаарт, тэр бэлчээртэй холбоотой асуудал байгаа юм.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Шадар сайд гүйцээгээд хариулаадахъя.

**С.Амарсайхан:** Энэ бэлчээр дээр анхаарах асуудал юу байна гэхээр мэдээж газар нутаг бэлчээрээ малчид маань тухайн тухайн орчиндоо хамгаалалгүй яах вэ. Гэхдээ энэ хүндрэл бэрхшээл гэдэг бол нэг малчин, нэг сумын асуудал биш болчихоод байна. Тэгээд нэг эх орон, нэг байгаль дэлхий дээрээ хэдүүлээ хүнд цаг үеэ хамтдаа хуваалцаж боломж, боломжоороо нөөцөө дайчлахгүй бол ирснийгээ хөөдөг, эсвэл бол мөнгө төгрөг өг гэж элдэв янзын үнэ, ханиш тогтоодог ийм байж болохгүй гэж байгаа юм. Нарийн яривал



энэ авлигал, хээл хахууль хууль бус орлогод тооцогдоно. Аймаг, орон нутгийн удирдлагуудыг бид малчдадаа зөв мэдээ, мэдээлэл өгч энэ зүйл бус дарамт, шахалтыг бие биедээ үзүүлдэг нь 5, 10 хонь сүргээ яая гэж байхад тэр хэмжээний мөнгө нэхээд сууж байдаг ийм аймаг, орон нутаг малчин байж болохгүй. Мэдээж бас энэ дээр хаа хаана анхаарах зүйл байгаа ч гэсэн хаана боломж байна түүгээ ашиглаж бид энэ цаг зудаа давж гарах ёстой. Цас зуд турхан гэдэг аюулт үзэгдэл гэдэг бол ганцхан тохиолдоод өнгөрдөг зүйл биш.

Тэгэхээр аяганы хариу өдөртөө, агтын хариу жилдээ гэдэг ишиг боломжтой газраа малчид маань отор, нүүдлээр явж байгаа хүмүүсээ хүлээж авч хамтарч ойлголцож ажилла, энэ хүндрэлээ даван туул гэж байгаа юм. Боломжгүй газар бол бас тэр зохицуулалтыг нь аймаг, орон нутгийнхан хий гэж байгаа юм. Энэ дээр Улсын онцгой комисс гэдэг юм уу, яам, тамгын газар гэхээсээ илүүтэй манай аймаг, сумдын орон нутгийн удирдлагууд өөрсдөө удирдаж, зохион байгуулж, малчдадаа зохицуулж ойлголцож, ойлголцуулж ажиллах ёстой гэдэг ийм удирдамж, чиглэлийг энэ жил ч биш хэдэн жилийн өмнөөс өгөөд л бид хяналтыг нь тавиад ажиллаж байгаа. Гэхдээ энэ дээр бас цаашид ч хөдөө аж ахуй хаанаа анхаарах асуудлууд бий.

**Ж.Батжаргал:** Туваан гишүүн асуулт асууя.

**Ц.Туваан:** Өвөлжилтийн өнөөгийн байдал хэлэлцэж байна, тэгээд хоцорч байна. Бид бүхэн улс даяараа тийм дайнаа эрэхээр дариа нухна гэдэг ишиг энэ өвөлжилтийн хүндрэл өвөл жил болгон болдог өвөлжилтийн хүндрэл байна гэдгийг мэдсээр байж байгаад л яг энэ асуудал дунд орчихлоо л доо. Маш олон асуудлууд байна. Тэгээд тэрэн дундаас энэ Байнгын хорооны тогтоол гаргаж, Засгийн газарт чиглэл өгч, яаралтай арга хэмжээ авхуулах зүйлүүд дээр хэд гурван асуулт, саналууд байна.

Эхний асуудал нь энэ бензин, дизель түлштэй холбоотой асуудал. Ингээд л ярихаар л болох гэж байгаа, болно гээд л сайд нь ч хэлээд л л, яам нь хэлээд байдаг. Энэ Засгийн газар дотор байгаа энэ Шадар сайд болон Хөдөө аж ахуйн яамныхан бас энэ мэдээлэлтэй нэг танхимын сайдууд юм чинь энэ шахаж ажилладаг байлгүй дээ. Хөдөө орон нутагт тэр дарга нарын унадаг бензин машин байхгүй. Портер, Бонго гээд дизелиэр ажилладаг машинууд байгаа. Энэ дизель түлшний хангалтаа хэзээ жигдрүүлэх юм бэ? Энэ бол яагаад ч малчид өөрсдөөс нь нутаг орон, нутгаас, өөрсдөөс нь шалтгаалахгүй ийм асуудал шүү дээ. Энэ дээр энэ Уул уурхай яамны газрын дарга, сайд чинь өнгөрсөн долоо хоногийн 1 дэх өдөр энэ долоо хоногтоо асуудалгүй болчихно л гэсэн. Одоо 2 ямар байдалтай байна? Нэг асуулт.

Хоёрдугаарт, энэ малчид өвөлжсөөндөө одоо юм бууцаагчигхан. Энэ хүмүүс чинь өөрсдөө яагаад ч чадахгүй нэг зүйл байгаа юм. Тэр нь энэ зам. Сумын төв орж чадахгүй, тэндээс хүнсээ, өвс тэжээлээ, бензин тосоо авч чадахгүй асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр нь энэ аймаг, сумдын онцгой комиссууд энэ Онцгой байдлын ерөнхий газраас ямар чиглэл өгч байгаа вэ тэр зам гаргах дээр? Бид нар амьдрал дээр мэднэ шүү дээ. Зил-131 гээд машин байгаа, 100км-т 100 литр, хүндрүүлсэн нөхцөлд 150 литр идчихдэг. Жоохон бензин түли гаргаад өгдөг төсөв дээр байгаа мөнгийг уучихдаг. Тэгэхээр энэ дээр тийм трактор ч юм уу, арай хэмнэлттэй ийм техникийн асуудлыг бид нар ер нь бодмоор болчихсон.

Тэгээд техник байгаад нэг асуудал байгаа. Тэр нь юу гэхлээр нөгөө дальлуу гээд чирээд зам гараад байгаа юм. Энэ дээр яг боломж байдаг юм уу? Төмрийн хогонд бүх төмрүүд явчихсан, суман дээрээ энийг хийгээд байх боломж байдаггүй. Энэ дээр улс байна даа Онцгой байдлын ерөнхий газар асуудлыг нь шийдээд энэ айл хооронд сум руугаа явах

энэ замыг нь гаргах асуудал дээр ямар арга хэмжээ авч байна?

Гуравдугаарт нь энэ мал, нядалгаа, махтай холбоотой асуудал. Одоо чадалтай нь малаа жоохон тооны өмнө царигтай дээр нь нядалчихсан, чадалгүйнүүд нь шуурганы дагуу тавиад туучихсан. Одоо бүүр үхлээ, мал турчихсан. Зүүн талд Сүхбаатар, Дорнодод мал турчихсан байхад бусад газар тодорхой.

Тэгэхээр энэ хээрийн бой хийх, малаа бойлох энэ асуудал дээр ер нь ямаршуу бодлого явж байдаг юм болоо? Тийм, борлуулалтын асуудлыг нь бол яг ний нуугүй хэлэхэд дэмжмээр байгаа юм. Түүрүүн бас сайд ярих шиг боллоо энэ үнэд энэ нөөцийн мах гээд энэ балай юм чинь хотынхны хямд мах идүүлэх гэсэн энэ бодлого чинь Монголын махны бодлогыг, мал аж ахуйн бодлогыг, малчдын олон малтай байх гэсэн энэ зүйлүүдийг чинь хамгийн анхдагч утвар нөхцөл шүү дээ. Тэгээд л нөгөө хямд байлгах гэсэн тэр рүү олон зуун тэрбум төгрөг зарчихсан, нөгөө махны үйлдвэрүүд нь хүнд байдалд орчихсон гээд л байгаа юм. Энэ дээр ер нь цаашдаа ямар бодлого барьж ажиллах юм бэ? Энэ л ийм малчдын малыг үнэгүйдүүлсэн бодлого нь яваад л.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Хариулъя. Амарсайхан сайд.

**С.Амарсайхан:** Туваан гишүүний асуултад хариулъя. Ер нь зах зээлийнхээ зарчмаар явах ёстой гэдэгтэй санал нэг байгаа. Гэхдээ хямд мах гэхээсээ түүрүүлээд чанартай, дээрээс нь зах зээлийн үнэ өртөгтэй тохирсон ийм л мал, махны нийлүүлэлт, хангалтын тухай асуудал ярьж байгаа.

Гэхдээ энэ Улаанбаатар хотын иргэдийн бас үндсэн нийт Монголчууд бидний үндсэн хэрэглээ болсон хүнсний хангалт, нийлүүлэлт аюулгүй байдалтай холбоотой асуудал дээр бид малчид тохиролгүй, дээрээс нь иргэд ч айхтар

үндэслэлгүй үнэтэй өндөр үнээр өгөхгүй талаас нь хаа хаанаа харилцан үр ашигтай байх талаас нь л энэ тогтолцоо, зарчим руу нь явуулахыг оролдож байгааг бүгдээрээ мэдэж байгаа. Энэ дээр бол хүнсний яамны өөрийн бодлого явж байгаа. Экспортоо нэмэгдүүлэх бас бидний гол зорилго бол энэ махны үнэ өртгийг малчдад бас өгөөжтэй байхаар, дотоодын хэрэгцээнд мал, махыг бас харьцангуй боломжийн үнээр нийлүүлэхийн тулд л энэ нөөцийн махны асуудал, хөнгөлөлттэй санхүүжилт гэдэг л юм яригдаж байгаа шүү дээ. Одоо бид дотооддоо өөрсдөө мал, мах хангалттай байж байж, экспортын үнээр бас дотоодынхоо зах зээлд нийлүүлээд байх нь зохимжгүй. Тийм амьжиргааны боломж, нөхцөл ч бүрдээгүй байгаа. Хаа хаанаа энийг бодолцож байж шийдвэрлэх л ёстой асуудал учраас хамгийн боломжтой хувилбараар нь зохицуулж байгаа гэж ойлгож байгаа.

**Ж.Батжаргал:** Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгөөрэй.

**Г.Ариунбуян:** Туваан гишүүний асуултад хариулъя Генерал Ариунбуян байна. Тэр аймаг, сумын онцгой комисст Улсын онцгой комиссоос өвөлжилтийн бэлтгэл асуудлаа ханга, бэлтгэл, бэлэн байдлаа сайжруул гээд цаг хугацаатай үүрэг, даалгаврыг өгсөн. Энэ талаар түүрүүн Шадар сайд мэдээлэлдээ тодорхой дурдсан.

Ер нь дальнуугаар хангах, дальнуугаар ашиглаж зам гаргах асуудлыг цэвэр сумын онцгой комисс, сумын засаг захиргаа хариуцаж хийх ёстой. Энэ дээр бол зарим сумууд санаачилгатай байна, зарим сумууд санаачлахгүй байна. Ийм асуудлууд үүссэн. Хамгийн сүүлд Төв аймгийн Эрдэнэсант суманд нөхцөл байдал хүндрэхэд бид өөрсдөө ч хүртэл очиж ажилласан, холбогдох мэргэжлийн байгууллага Зэвсэгт хүчнээс дэмжлэг авч ажилласан. Тэр болгон энэ зам гаргах дальнуу хийх асуудал дээр бид нар

оролцох боломжгүй байгаа. Мэдээж хүндэрсэн аймаг, сумдад бид өөрсдийнхөө чиглэлээр дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах үүргээ хүлээж ажиллана гэдгийг хэлье.

**Ж.Батжаргал:** Ажлын хэсгийн 2 дээр үргэлжлүүлээд тэр шатахууны хангалтын асуудлыг тов тодорхой хариулт өгөөдөх дөө.

**Ч.Хишигдалай:** Уул уурхайн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Хишигдалай. Бензин, дизель түлшний орон нутгийн хангалтын талаар бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар бол маш их хичээж ажиллаж байна. Өнгөрсөн 15-ны өдөр 360 сумтай холбогдсон 344 сумын Засаг даргатай биечлэн ярилцсан. Байдал дээр бол 61 сум дээр бол дизель түлш хязгаарлалттай олгож байна, бусад нь хэвийн байна гэсэн. Хязгаарлалттай гэдэг маань бас бүүр тасалчихгүйн тулд тодорхой хэмжээний мөнгөн хязгаар тогтоогоод хэрэгцээ шаардлагатай хүмүүст нь өгөөд явж байсан. Энэ мэдээллийг бид аж ахуйн нэгжүүдтэй холбогдож өгөөд тухайн сумууд руу газрын тосны бүтээгдэхүүн, дизель түлшийг ачуулсан байгаа. Орон зайнаас шалтгаалаад 3 хоногийн дотор бол хүрнэ. Түрүүн Тэмүүлэн гишүүний дурдсан Цахир сум руу гээд хэлэхэд жишээ нь 16-ны өдөр шатахуун ачсан автомашин гарсан, өнөөдөр очиж байгаа байх гэж бодож байна гэх мэтчилэн бид нар шуурхай арга хэмжээ авч байгаа. Дизель түлшний Оросын Холбооны Улсаас нийлүүлэлт бол хэвийн болсон, хангалттай хэмжээний нөөц бүрдэж байна. Орон нутаг руу бол ачилтыг тасралтгүй хийж байгаа

**Ж.Батжаргал:** Туваан гишүүн тодруулъя.

**Ц.Туваан:** Яах вэ бид нар ингээд тийм тулга тойрсон жижиг, сажиг асуудлууд би нэг нь асуугаад, зарим нь хариулаад л явж байна. Энэ малчид

яагаад ийм олон мал маллаад бэлчээргүй болчихоод байхад бэлчээргүй болгоод байгаа гэдэг асуудлууд энэ малын өвчлөлтэй чинь холбоотой байгаа шүү дээ. Экспортод мал гаргах энэ малыг эрүүл байлгах гоц халдварт өвчнөөс тайван байлгах гэдэг энэ асуудал дээр одоо бид нар хууль, эрх зүйг нь шинэчлээд боломжит малаа боломжтой түвшин хүртэл нь экспортод гаргахгүй бол энэ асуудал чинь маш олон эрсдэл, хүндрэлүүдийг дагуулж байгаа юм.

Хоёрдугаарт энэ малын үнэгүй байдал, түүхий эд үнэгүй. Дарханы арьс ширний цогцолбор гээд л яриад л энийг оруулъя гээд хэдэн жил ярив. Одоо өөр улсын бодлого явуулах гэж байгаа юм шиг ингэж хязгаар тавьж ингэсээр байгаад л өнөөдөр бид нар яг.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Туваан гишүүн үргэлжлүүлээд тодруулаад асуучих.

**Ц.Туваан:** Ийм дэмжлэггүй энэ бодлогууд чинь эргээд энэ малыг үнэгүйдүүлээд, үнэгүй мал чинь яах вэ бага үнэтэй мал олныг маллаж байж хэрэгцээгээ хангана. Энэ чинь эргээд Монгол орныг, бүүр сүүлдээ дэлхий рүү хүртэл нөлөөлөхүйц ийм юм болчихлоо. Тэгэхээр Хөдөө аж ахуйн сайд энэ малын гоц халдварт өвчнөөс тайван байлгах энэ бодлого, хууль, эрх зүй дээрээ хэдүүлээ ярилцаж тодорхой шийдэл гаргах асуудал байгаа шүү.

Дараагийн асуудал энэ малчдад энэ Засгийн газрын тэр шийдвэр чинь яг юу болчхов? Тэрийгээ одоо хэлээд өгөөч. Төв аймгийн малчид жишээлбэл сумууд тэжээл 50 хувийн хямдралтайгаар яаж авах юм бэ? Ер нь бол нэг зүйл нь энэ сум дээр нь л энэ тэжээлийг нь худалдаж авах, тэжээлийг нь ойртуулаад өгчих боломжоор л хангах байгаа юм л даа. Үнэгүй өгөхөөсөө илүүтэйгээр. Тэгэхээр энэ дээр тэр Засгийн газрын шийдвэрээр та яг хэлээдхээч Төв аймагт хэчнээн тонн хямдрал.../минут дуусав./

**Ж.Батжаргал:** Баярхүү нөөцийн тэжээлийн хуваарилалт, үнэ хөнгөлөлтийн асуудлаар товчхон мэдээлэл өгөөдөх. Ажлын хэсгийн 3.

**Т.Баярхүү:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Туваан гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын өнгөрсөн долоо хоногийн хуралдаанаар нийтдээ 4000 орчим тонн хивэг, тэжээл, 1200 орчим тонн хорголжин тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр хуваарилсан. Энэ улсын нөөцийн цэг байдаггүй Сэлэнгэ аймгаас бусад бүх аймгууд дээр энэ тодорхой түвшинд хуваарилалт хийж байгаа.

Төв аймгийн тухайд 130 тонн хивэг, 162 тонн хорголжин тэжээл 50 хувийн хөнгөлөлттэй үнээр эхний тогтоолоор хуваарилагдсан байна. Одоо дараагийн тогтоолыг бас оруулахаар бэлдэж байгаа гэдгийг хэлье. Энийг бол аймаг, орон нутгийн онцгой комисс дээр зохион байгуулж байгаа. Шууд улсын нөөцийн цэгүүдээс гаргаж байгаа учраас тухайн сумууд дээр нь шууд хуваарилалт нь очих ёстой.

**Ж.Батжаргал:** Наранбаатар гишүүн асуулт асууя.

**Н.Наранбаатар:** Өвөлжилт ер нь нийт нутгаар л хүндэрчихлээ. Говийн аймгууд уг нь гайгүй байсан энэ сүүлийн амралтын өдрүүдээр орсон цаснаас эхлээд бол ер нь зөвхөн Өмнөговь аймгийн хэмжээнд нийт нутгийн 70-80 хувь нь цасан бүрхүүлтэй болсон. Ялангуяа хойд талын болон зүүн талын сумуудаар ахиу хэмжээтэй орсон, олон мал уруудсан, малынхаа араас явсан, бензин шатахуунгүй болсон хүмүүс олон. Ханхонгор сумд 1 хүн урьд шөнө алга болоод одоо хүртэл олоогүй эрлийн баг ажиллаж байх шиг байна. Сүүлд сая мэдээ авсангүй. Олдоогүй гэсэн мэдээ энэ хуралд орохоос өмнө авсан. Малчид юу ярьж байна вэ гэхээр зэрэг сая гишүүд ч бас ярилаа. Нэгдүгээрт бол энэ шатахууны асуудал малын эрэл хайгуулын араас явж байгаад түли

дууссан асуудлууд тулгамдсан асуудал байна.

Хоёр дахь асуудал нь энэ өвс, тэжээлийн Улсын онцгой комиссын өвс, тэжээлийн хямдралтай үнээр малчдад борлуулах асуудлыг их тавьж байна. Тийм учраас сая Туваан гишүүн бас асуусан. Тэрэнтэй адилхан бас энэ говийн бүс нутаг ялангуяа энэ Өмнөговьд хэдий хэмжээний тэжээл 50 хувийн хямдралтай хуваарилагдаж байна вэ, цаашидаа нэмэгдүүлэх үү, нөөц хэр байгаа вэ? Өвсний асуудал бас яригдаж байна. Энэ дээр бас цаашидаа ямар арга хэмжээ авах вэ гэсэн ийм бас Улсын онцгой комиссоос, Засгийн газраас бас өвөлжилттэй холбоотой нэлээд олон асуудлууд бас авч хэрэгжүүлж байна. Тэгтэл бас хүч хүрэхгүй байгааг хөдөө аж ахуй хаанаа бас л бүгдээрээ мэдэж байгаа.

Аймгуудад ер нь бол Засгийн газрын нөөцөөс бас тодорхой хэмжээний хөрөнгө, төсөв хуваарилж өгвөл бас их үр дүнтэй байдаг. Ялангуяа энэ малчид руугаа явах, ирэх очих шатахуун, төрийн албан хаагчдын томилолт гээд сумууд маань бас хүндрэлтэй ийм нөхцөлд бас тодорхой хэмжээний хөрөнгө, мөнгө хуваарилж өгөх юм бол бас энэ хүнд үед бас дэм болох байх гэсэн ийм бодолтой байгаа.

Дээрээс нь нэмээд энэ Хэмнэлтийн хуульдаа бас яаралтай өөрчлөлт оруулах асуудал яригдаж байна. Үүнийг бол миний хувьд гишүүний хувиар бол бүрэн дэмжиж байгаа. Харин яаралтай энэ хуулиа оруулах шаардлагатай байх.

Мөн бас нөгөөтээгүүр бас энэ хил залгаа аймгууд, хойд, урд хөрш аймгуудаас хил залгаа аймгууддаа бас тусламж дэмжлэгээр өвс, тэжээл өгөх ийм туршилага бол өмнө жилүүд байдаг. Энэ дээр бас та бүхэн онцгой анхаарч ялангуяа Оросын Холбооны Улс, Хятадад байгаа консул, элчин сайд нар энэ дээр бас аймгуудын Засаг дарга нарт дэмжлэг үзүүлэх юм бол бас тодорхой



тоо хэмжээгээр орж ирж байсан туршлага бас байгаа урьд өмнө. Ийм асуудлууд байна. Асуулт нь бол тэр говийн бүс нутаг, Өмнөговь руу хуваарилагдаж байгаа өвс, тэжээл, мөн шатахууны хүрэлцээ хангамжийн асуудлаар шинэ мэдээ аваадахъя.

**Ж.Батжаргал:** Хариулъя. Ажлын хэсгийн 2.

**Г.Ариунбуян:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын тогтоолын дагуу Өмнөговь аймагт 50 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр тэжээл 283 тонныг олгохоор шийдвэрлэсэн. Ирэх долоо хоногт энэ аймаг, сумдад хүргэх ажлыг зохион байгуулна. Цаашид ер нь энэ өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулаад Өмнөговь аймгийн улсын нөөцийн салбар цэгт бүрдүүлсэн өвс, тэжээлийг бас хөнгөлөлттэй үнээр олгох асуудлыг ингээд Засгийн газрын шийдвэрийн дагуу зохион байгуулаад явна гэдгийг илтгэе.

**Ж.Батжаргал:** Ажлын хэсгийн 2.

**Ч.Хишигдалай:** Өмнөговь аймгийн шатахуун хангамжийн талаар мэдээллийг авсан. Даланзадгад буюу аймгийн төвтэй бол холбогдож чадаагүй, хувийн шугамаар компаниас “Ккомпаниас авсан. Бусад сумд дээр бол шатахууны хангалт бол бусад аймгуудыг бодвол хамгийн хэвийн байна Өмнөговь аймаг. Тодорхой хэмжээгээр багассан газрууд руу бол байнгын ачилт явж байгаа. Манай газар Ашигт малтмал, газрын тосны газартай хамтраад энэ агуулахуудаас орон нутаг руу ачигдаж байгаа шатахуун түлш дээр бас хяналт тавьж ажиллаж, судалж явж байгаа. Энэ дээр Өмнөговь руу хамгийн их ачигдаж байгаа.

**Ж.Батжаргал:** Болорчулуун сайд тодотгож хариулт өгье.

**Х.Болорчулуун:** Би харин гишүүний хувьд асуулт асуудаг юм уу.

Бас онцгой байдлынхандаа хэлэхэд цас, зуд ингээд тодорхой цагийн аясаар байхгүй болно. Залгуулаад хаврын эрсдэлтэй үед салхи шуургатай үед түймэр их гарна. Тэр тусмаа зүүн аймгуудын нутгаар түймэр их гардаг. Энийг урьдчилан сэргийлэх арга хэмжээг бол энэ бас эртнээс Онцгой байдлын алба, шуурхайгийхан маань бас бодлого болгож ажиллаж баймаар байна. Өнгөрсөн жил гэхэд Дорнод аймагт, Хэнтий, Сүхбаатар аймагт бол маш их түймэр гарсан, олон мянган мал сүйдсэн.

Тэгэхээр баруун аймгуудтай харьцуулахад энэ хаврын эрсдэл зүүн аймгуудад өндөр байдаг шүү. Энэ дээр анхаарч тэр хувцас хэрэглэл, машин тоног төхөөрөмж энэ болгон дээр бас анхаарч ажиллаасай гэж хэлмээр байна. Сая өвөл Халх гол сумд явж байхад орон тоо нь гэхэд Халх гол сумын Онцгой байдлын хэлтэс 40 орон тоотой, тал хүнээр ажиллаж байна. Цалин хангамжид тийм сайн биш, хувцас хэрэглэл муутай, ялангуяа түймэр унтраах багаж хэрэгсэл муутай гэдгээ бас хэлж байна. Ийм учраас хүмүүс бас тогтоож өгөхгүй байна. Хэлтэс байгуулаад үр дүн гарахгүй байна шүү гэдгийг бас хэлж байна шүү. Энэ дээр бас анхаарч үзээч. Бусад аймгууд бас онцлог шүү энэ хаврын үед гэдгийг бас анхаарч ажиллаасай гэдгийг хэлэх байна.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Санал байлаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж санал хэлэх гишүүд. Тэгэхдээ үүнийг бас хэдүүлээ нэгэнт асуудал хэлэлцэж байгаатай холбогдуулаад Байнгын хорооноос тогтоол батлагдахаар тогтоолын төсөл та бүгдэд хүргэгдсэн.

Тийм учраас тогтоолын төсөл дээрээ тухайлсан заалт дээр санал, бодлоо илэрхийлээд явчих нь бараг зөв байх. Тэгж байж энэ бас хуралдааны шуурхай байдал, ажил хэрэгч байдал

хангагдах байх гэж ингэж ойлгож байна. Нэрсээ өгье. Санал хэлэх гишүүд. Тэмүүлэн гишүүн, Дамдинням гишүүн, Туваан гишүүн, Болорчулуун гишүүн, Наранбаатар гишүүн, Бейсен гишүүн орчихсон юм байна. Бейсен гишүүн үг хэлье. Туваан гишүүнийг нэмээрэй.

**Б.Бейсен:** Энэ малын тэжээлийн импортын асуудал дээр Улсын онцгой комисс, Шадар сайд, Хөдөө аж ахуйн яам хамтарч байж энэ баруун аймгуудын гааль, импортын татвараас чөлөөлөх шаардлагатай байна гурил энэ тэрийг, бас хямдаар авах боломж байна. Нөгөө талаар малчид чинь ноднингийн малын тэжээлийн өрнөөс салаагүй байгаа шүү дээ. Нөгөө талаар ялангуяа энэ баруун аймгууд дээр чинь бараг 6 сар хүртэл өвс ногоо гардаггүй шүү дээ. Хүйтэн, өндөр бүс.

Тийм учраас энэ асуудал дээр анхаараад тэр импортын татвар, гаалиас чөлөөлөх асуудал дээр анхаарч өгөөрэй. Бараг малдаа өвс тэжээл өгөөд эхэлчихсэн байна. Одоогоор яг 25-28 мянга хүрчихсэн байна пресс өвс аймагт. Үүнийг бас анхаарч үзэх шаардлагатай байна.

Нөгөө талаар энэ малчид бас өвлийн идшээ бэлдсэн. 1 бод, үхэр адуу ч юм уу 8 бог гаргадаг, 10 бог. Үүний бүх арьс энэ тэрийг нь хогонд хаяж байна. Уг нь малын арьс, ширээр тэжээл, хивээг авдаг байсан. Мал нь зарагдахгүй хүйтэн газар ихээр нядалж байна, зарж байна, бас үнэ хүрэхгүй байна.

Тийм учраас баруун аймгууд дээр энэ бүсчлээд малын түүхий эд боловсруулах үйлдвэрийг яаралтай барих шаардлагатай байх даа. Ноос, арьс, шир боловсруулах үйлдвэр энэ дээр анхаарах шаардлагатай юм байна.

Саяын тэр Хөх сэрхийн нуруу, Дундговь, Ховд аймгийн тэр Ховд сумын Дунд гол дээр оторлож очсон 10 суурь мал байгаа Булган сумын. Эднийх чинь 3 сая төгрөгөөр торгоод шүүхээр зар...

гээд ингээд хөөгөөд байгаа юм. Байгаль орчны сайд ч анхаарахгүй байна, зудын байдалтай байна. Онцгой комисс энийг анхаараад хүчингүй болгож өгөөч л гээд байгаа юм. Өөр зайлуул буцах замгүй болчихсон. Очих өдөр мал бэлчих газаргүй. Ийм байдлаар хандаж болохгүй гэж бодож байна. Тэр бензин, шатахууны нөөц бүрдүүлэх тал дээр анхаарахгүй л зудын байдалтай болсон. Эмнэлэг хүрэх бензин шатахуун байхгүй, түргэн тусламжийг нь авахад боломж бас муудаж эхэлж байна. Эрүүл мэндийн яам ялангуяа ингээд сууж болохгүй. Аймгуудын Эрүүл мэндийн газарт бас мэргэжилтнүүд байж байна. Энийг шахаад сумын хэмжээний бүх аптека энэ тэрийг, малчдыг тэр яаралтай тусламжийн бүрэлдэхүүнээр хангах тал дээрээ яахгүй бол бид нар энэ олон улсын байгууллага энд тэнд хэлсэн гэдгээр цаас шийдчихээд сууж ерөөсөө болохгүй. Газар дээр нь шалгах ёстой. Бэлэн байдлыг шалгахгүй бол энэ үнэхээр болохгүй асуудал байж байна.

Түргэн тусламжийн машины асуудал байж байгаа. Энэ зарим нь шийдэгдээгүй л байж байгаа. Шийдсэн яамны мэдэлд өгчихсөн, аймгуудад өгчихсөн гээд тэгж байгаа юм. Энэ бодит байдлаар тийм юм байхгүй шүү энэ дээр бас анхаарч ажиллах шаардлагатай байна. Ийм л санал хэлье. Баярлалаа.

**Ж.Батжаргал:** Тэмүүлэн гишүүн нэрээ авчхаж байгаа юм байна. Дамдинням гишүүн, Болорчулуун гишүүн бас нэрээ авчхаж байгаа юм байна.

**Г.Дамдинням:** “Өвөлжилтийн өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний эрчимжүүлэх талаар авах тухай” тогтоолын төсөл Улсын онцгой комиссын мэдээллийг сонсож байна. Тэгээд энд нэг юмыг би ерөөсөө огт байхгүй байгаад их гайхаад байх юм. Сүүлийн үед энэ салбарын яамныхан гаргаж байгаа шийдвэр ч гэсэн амьдралгүй, нөхцөл байдалдаа таарахгүй ийм л байдалтай байна. Малчдынхаа

асуудлыг бас энэ орон нутгийнхаа асуудлыг бид ярилгүй л яах вэ. Яриад шийднэ.

Энэ тогтоол дээр энэ боловсролын үйлчилгээтэй холбоотой асуудлыг тусгаж өгөх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол энэ манай Боловсролын яам чинь гэнэт нэг өглөө босож ирээд л ямар ч бэлтгэл ажил байхгүй аав, ээж хүмүүс чинь ахуй амьдралаа төлөвлөчихсөн байж байгаа гэнэт л цахимаар хичээллэнэ гээд л явчих юм. Яасан? Их хүйтэн болоод байна, баахан ханиад хүрээд байна. Өнөөдөр Эрүүл мэндийн яамны өгч байгаа мэдээллийг нь харахтай зэрэг нийт ханиад томууны тохиолдлын 91 хувь нь 0-5 насны хүүхдүүд байна гэж мэдээлсэн байна лээ.

Ерөнхий боловсролын сургуулиа цахимаар хичээллүүлээд аюул болоод байгаа мөртөөсөө цэцэрлэгт хамгийн их өвчлөлтэй байгаа хэсгээ болиулаагүй байгаа байхгүй юу. Та нар Улсын онцгой комисс дээр энийг яриач дээ. Тэгээд энэ ажлын хэсэг нь ороод ирсэн тэр Боловсролын яамных нь хүмүүс байхгүй. Дархан-Уул аймгаас манай сонгогчид бас хэлж л байна л даа. Маш олноороо бөөн бухимдал. Хүмүүс чинь бид нар шиг бас өглөө босож ирээд л манай Боловсролын сайд шиг өглөө босож ирээд л гэнэт шийдчихдэггүй шүү дээ амьдралаа. 14-хөн хоногийн хооронд тэгээд л ийм асуудал гаргаад байх юм. Цар тахал даваад гараад ирчихсэн хүмүүс шүү дээ бид нар энэ менежментээрээ. Дайны үед ч гэсэн энэ боловсролын салбарыг зогсоож болдоггүй шүү дээ.

Тэгэхээр энийг бид нар тасралтгүй энэ үйлчилгээг нь явуулж байх чиглэл дээр нь анхаарал татахгүй бол сая олон улсын үнэлгээнд Монголын боловсрол орсон. Хөдөө сумын хүүхэд аймгийн төвийн хүүхдээсээ боловсролоороо 1.5-2.5 дахин хоцорчихсон. Улаанбаатар хотын хүүхдийн боловсролын түвшин аймгийн төвийн хүүхдээс 1.5-2.5 дахин илүү боловсролын ялгарал руу явчихсан.

Боловсролын энэ эвдрэл, гэмтэл энэ гэнэтийн шийдвэрүүдийн чинь үр дүн энэ зуд турхнаас чинь аюултай зуд турхныг тарина шүү дээ ирээдүйд. Онцгой комисс дээрээ та нар энийг ярихаараа бас ярих хэрэгтэй байна шүү дээ. Ярьж байж шийдэхгүй бол энэ хүмүүс чинь амьдарч байгаа шүү дээ бас. Тэгээд бас энэ үнэхээр хүндрэлтэй байгаа хэсгүүд дээрээ энэ карантин юмнуудаа авдаг юм байгаа биз. Гайгүй байгаа хэсгүүд дээрээ явуулж байдаг энэ бодлогыг энэ Боловсролын хуулиар зөвшөөрөөд өгчихсөн шүү дээ. Та нар Онцгой комисс дээрээ энэ Боловсролын яамны гэнэт шийддэг дарга нарыг авчирч байгаад энэ асуудлыг бас шийдсэн нь дээр байх, ярилцаарай.

Хоёрдугаар асуудал бол энэ экспортын үүд хаалгыг нээх чиглэл дээр л гол асуудлаа тавимаар байна. Алийн болгон бид нар л жил болгон улсын төсөв гээд л, тэгээд л Онцгой комисс гээд л л явах юм бэ? Малчид маань орлогоо нэмж байж л, маллаж байгаа малынхаа үнэ цэнийг нэмж байж л, малаасаа гарч байгаа бүтээгдэхүүнийг өндөр үнээр зарж байж л энэ асуудлыг шийднэ шүү дээ. Хадлан тэжээлээ өөрсдөө бэлддэг болно, худалдаад авдаг болно, сайн үйлдвэрийн мал худалдаж авдаг болно, хашаа хороогоо барина.

Тэгэхээр энэ Онцгой комиссынхоо хүрээнд бас та нар энэ Засгийн газарт энэ экспортын үүд хаалгыг нээж энэ малчдынхаа ашиг орлогыг нэмэгдүүлэх чиглэл рүү их маш тодорхой саналуудыг энэ тогтоолын төсөл дээр бүүр оруулмаар байна.

Гуравдугаар асуудал бол энэ бензин, түлштэй холбоотой асуудал. Бензин, түлштэй холбоотой асуудал дээр энэ малчид хөөрхий минь адуу малаа хайгаад шуурганд уруудчихсан байгаа энэ малаа хайгаад явах гэхээр бензин тосгүй болсон, үр хүүхдээ эргэж чадахгүй байна гэнэ. Тэгэхээр энэ дээр нь бас та нар хэрэгцээ шаардлагыг нь хангаач.

Төгсгөлд нь нэг юмыг хэлье. Энэ уул уурхайн тээврийн дизель түлшнүүдийг тасалчихсан. Одоо энэ Тавантолгойгоос энэ Ганц мод руу цаашаага явдаг ч билүү, Ханги руу явж байгаа бас тээвэр байгаад байгаа шүү дээ. Мянган км тээвэр. Энд явж байгаа машинууд бас бензингүй болчихсон. Хүн хөлдөж үхнэ шүү тэнд Уул уурхай яамныхан энийг анхаараарай. Ийм л юмнууд хэлье дээ.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Наранбаатар гишүүн.

**Н.Наранбаатар:** Тогтоолын төсөл дээр харж байхад шатахууны асуудал 3 заалтад орчихсон байна. 2 дахь заалтад шатахууны нөөцийг бэлтгэ гэж байна. 5 дахь заалтад бензин шатахуунд дизель түлшний хангалт, нийлүүлэлтийг нэмэгдүүл гэж байна. 8 дахь заалтад шатахууны нөөц бүрдүүлэх, зарцуулах, орон нутагт ажиллах зардалд зориулж гэж байна. Шатахууны асуудлууд нэгтгэчихвэл яасан юм бэ гэсэн юу байна. 7 дугаарт нь тэжээл гэдгийн өмнө өвс гээд оруулчихвал яасан юм гэсэн ийм нэг л санал.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Туваан гишүүн.

**Ц.Туваан:** Түрүүн бас хэлж байсан энэ Байнгын хорооны тогтоолд хууль, эрх зүйтэй юм нь яаж ордог юм? Энэ бид нар энэ малаа экспортод гаргаж чадахгүй байгаа, улсаараа энэ улаан гэрэл асдаг байдал чинь энэ шүлхийтэй холбоотой. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ ер нь бараг мэдэж байгаа шүү дээ яагаад шүлхий гараад байгаа юм, яагаад улс даяараа вакцин тариад байгаа юм энэ тэр гээд энэ асуудлаа улс юм чинь энэ хил гаалиудаар л орж ирээд байгаа шүү дээ хилийн бүс орчмоосоо. Энэ хавиа хэдүүлээ тусгаарлаж байгаад яг тэрнийхээ дагууд нь вакцинжуулж байгаад бусад улсаараа эрүүл бүс болох энэ асуудал дээрээ ярих цаг нь болчихсон.

Хэрвээ энэ асуудлаа шийдчих юм бол бид нарт экспорт нээгдэнэ, экспорт нээгдвэл малын үнэ нэмэгдэнэ. Малын үнэ нэмэгдвэл ингэж олон мал чанаргүй олон малтай байж бэлчээрээ сүйтгээд малчид чинь өөр өөрсдөө мал маллах хүнгүй боллоо шүү дээ. Өөрсдөө өвчин хуучин нь барагдаад, ядарч туйлдаад байх шаардлага байхгүй. Тэгэхээр энэ дээр ерөөсөө шалтгаан энэ байгаа шүү. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ бас одоо хууль, эрх зүй талаасаа нэлээн цаг зав гаргаж байгаад ярилцсан нь зөв.

Дараагийн асуудал тэр Онцгой байдал дээр бас онцгойгийнхон хийдэг ийм аюул, осол, үер ус, ган гачиг, зуд турхан болохоор л шахаад суучихдаг, Онцгой дээр бас ийм алхам хиймээр байна. Энэ ялангуяа энэ бага түлш иддэг, хүчин чадал сайтай, юм хөгжчихсөн шүү дээ энэ техник юм хум авахад нь бас зориулсан ийм төсөв дээр нь санал гаргадаг юм уу, яадаг юм. Тэр дальпуу гэж байна яах вэ мэдээж сум нь хариуцах ёстой. Сум нь хариуцаж байгаа гээд байгаа байдал чинь хэдхэн хөнгөн жингийн сарзгар төмөр гагнаад, нэг чирч ирээд л зад үсэрдэг шүү дээ. Ариунбуян дарга та тэрийг мэдэж байгаа. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ бас стандарт гаргаад хэмжээсийг нь ядаж өгөөд тийм нэгдмэл байдлаар зохион байгуулчихвал энэ бие бие рүүгээ түлхэх биш бас нэлээн шийдэх ийм асуудал гэж ингэж бодож байна.

Хоёрдугаарт тэр Дархан, Сэлэнгэ, Төв гээд энэ Булган гээд энэ импортынхоо тариалангийн гол бүс нутгууд дээр энэ борлогдоогүй улаан буудайн үлдэгдэл байгаа. Энэ дээр бид нар бас анхаарч ажиллах ёстой. Энэ үлдэгдэл гээд л тэгдэг яамныхан тоо гаргаад өгчихдөг. Төв аймагт байхгүй байна л гэдэг, Дархан, Сэлэнгэд тэд байна л гэдэг. Тэгэхээр энэ тоонуудаа нягталж үзээд энэ борлогдоогүй улаан буудайн үлдэгдэл дээрээ одоо шийдэл гарга.

Ер нь цаашидаа энэ Болорчулуун сайдын юунд ч гэсэн гарч байна лээ тэр



Засгийн газрын шийдвэр гэнэ үү. Улаан буудайн импорт гээд тэгээд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, дотоодоосоо нөгөө юмаа 100 хувь хангачихсан гээд байгаа чинь хаана яваад байгаа юм? Нэг болохоор 100 хувь хангачихсан илүү байна гэж ярьчихаад нөгөө талаараа улаан будаа импортлоно гээд л яриад байгаа. Тэгэхээр энэ чинь хоорондоо зөрчил үүсгэхгүй байгаа юм уу, зөв бодлого юм уу эсвэл? Хүнсний ногоон дээр л импортын татварыг маш өндөр тавьж нэмэгдүүлнэ л гээд байгаа юм. Тэгсэн хэр нь адилхан хүнсэнд ордог улаан буудайн дээр импорт явна л гээд байгаа юм. Би энийг бас сайн ойлгохгүй байгаа юм. Энэ ямар нь болохоор ийм болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ улаан буудайн импорт чинь л дагаад баахан улаан буудай ороод ирдэг, эргээд энэ тариаланчид чинь энэ цохилт болохгүй юу? Энэ дээр тооцоо, судалгаа бас хийж өгмөөр ийм санагдаж байгаа юм.

Тэгэхээр энэ борлуулагдаагүй байгаа улаан буудайн үлдэгдэл дээр бас энэ Байнгын хорооны тогтоолд тодорхой асуудал оруулж өгмөөр байна. Энэ дээр энэ 11 зүйлтэй саналын 2 дээр шатахууны асуудал, 5 дээр шатахууны асуудал, дахиад тэр хойно 8 дээр шатахууны асуудал гээд ер нь шатахуунтай холбоотой энэ асуудлууд чинь маш асуудал болчихсон байна гэдэг нь тодорхой байгаа учраас энийг тийм хугацаатай ч юм уу, ер нь ямар нэгэн байдлаар нэгтгээд нэг дорвитой томоохон нэг заалт болгодог юм уу, тийм тодорхой энд тэнд бичээд бага багаар бичээд яах биш нэг том заалт болгоод оруулъя гэсэн ийм саналтай байна.

**Ж.Батжаргал:** Баярлалаа.

Тэгэхээр энэ мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний асуудал өнөөдөр сөрөөд ярьж байгаа зүйл биш. Энэ аль зунаас эхлээд энэ салбарын өвөлжилтийн бэлтгэлийг хангах үүрэг, даалгавар бүх юмнууд яваад, гүйцэтгэл юмны мэдээллүүд сонсоод, саяхан 14 хоногийн

өмнө Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр мэдээлэл сонсогдсон. Үүний дагуу гишүүдээс маш олон санал, хүсэлтүүд гарсан.

Тийм учраас үүний мөрөөр зохиож байгаа ажил үр дүн ямар байна гэдэг мэдээллийг Байнгын хороо зориуд сонсож, бас шийдвэрлэх ёстой асуудлуудыг нь шийдвэрлэх ёстой. Тийм учраас Засгийн газарт чиглэл өгсөн шийдвэр гаргах ёстой гэж өнөөдөр зориуд нэмэлтээр оруулж ирж ингэж хэлэлцэж байгаа асуудал гэдгийг нэгдүгээрт хэлчихмээр байна.

Хоёр дахь зүйл манай Улсын онцгой комисс, Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнууд цагийн нөхцөл байдлаа үнэлж хойшлуулишгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээ цаг хугацаанд нь авч хэрэгжүүлж байгаа. Тийм учраас би авч хэрэгжүүлж байгаа гэж ингэж ойлгож байгаа.

Гэхдээ мэдээж тодорхой салбар хоорондын зохицуулалт, харилцан мэдээлэл солилцоо, түүний гүйцэтгэл, үр дүнд тавих хяналтын асуудлууд бидэнд байгаад байгаа юм. Тийм учраас Улсын онцгой комисс бол аймаг, сумдаа бүгд Онцгой комисстой. Тийм учраас энэ яригдаж, хэлэгдээд байгаа ажлууд орон нутгуудад хэрхэн явагдаж зохицуулалт нь хангагдаж байна вэ, нөхцөл байдал яаж үүсэж байна вэ, түүнийг арилгах талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой вэ гэдэг энэ харилцан мэдээлэл солилцоо хяналтынхаа юмыг босоо бүтцээрээ бараг өдөр болгон авах бололцоо байгаа. Тийм учраас үүнийгээ нэлээн сайн авч хэрэгжүүлээрэй гэдгийг нэгдүгээрт хэлчихмээр байна.

Хоёр дахь зүйл. Аливаа зүйлүүд дандаа тоотой, нөөцтэй. Одоо тэжээл гэхэд 92 мянган тонн тэжээлийн будаа тэжээлийн үйлдвэрүүдэд оччихсон, наад гурилын үйлдвэрүүд чинь 190 мянган тонн улаан буудай авсан 30 хувь нь тэжээл гардаг нь үнэн юм бол 50 хэдэн

мянган тонн 60-аад мянган тонн тэжээл гарах ёстой. Дээр нь манай тариаланчид дээр чанарын тодорхой асуудлаас хамааралтай 62 мянган тонн будаа борлогдоогүй байж байгаа. Ингээд үзэх юм бол бараг 210 хэдэн мянган тонн тэжээлийн будаа хийгээд, тэжээл гарах нөөц бидэнд байгаа.

Гэтэл өнөө гахай, шувуу тогтмол хэрэглээтэй өнөө эрчимжсэн мал аж ахуйн чинь хэрэглээ жилийнхээ туршид хэд вэ, үүссэн энэ цагийн байдалтайгаа уялдуулаад бэлчээрийн мал аж ахуйд чинь нэмэлт шаардлагатай тэжээлийн нөөц хэд вэ гэдэг тооцоо судалгаагаа хийгээд л үүн дээрээ тулгуурлаж импортын асуудал яригдах ёстой нэг.

Хоёрдугаарт бүс нутгийн онцлог байгаад байгаа юм. Улаанбаатараас баруун аймгууд руу гэдэг юм уу тээвэр хийхээр зэрэг нэг л бүтээгдэхүүн дээр ноогдох тээвэр ложистикийнх нь зардал өндөр болчхоод асуудлыг улам хүндрүүлээд болж өгөхгүй байна. Тийм учраас тэр бүс нутгийн боомтуудаар нь бас татварын хөнгөлөлттэй нөхцөлөөр өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг нь, гурилыг нь, тэжээлийг нь, шатахууныг нь оруулж ирээд нийлүүлчих асуудлыг судлаад зохицуулаадхаач гэдэг ийм чиглэл үүргийг өгч байгаа юм гэдгийг хэлье.

Манай гишүүд тогтоолынхоо төслийг сайн анзаарсан байлгүй дээ. Энэ эрүүл мэндийн салбар, нийгмийн үйлчилгээ тал дээрээ шатахуун гэж орсон нь өнөө нөөц бүрдүүлэлттэйгээ холбоотой. Нөгөө талд нь нийт улсын хэмжээний шатахуун түгээлттэй холбоотой асуудал орчихсон.

Дараачийнх нь наад аймаг, сумын Онцгой комиссуудын чинь ажиллах нөхцөлийн хүрээнд шатахууны нөөцтэй байлгах үүднээс хөрөнгийг нь шийдэж өг гээд байгаа юм. Тэр нь та нарын яриад байгаа тэр хаагдсан зам, давааг нээх, онгойлгох энэ Онцгой комиссынх нь нөхөд, анги салбарууд нь орон нутагт

ажиллах барих гээд олон асуудлуудад шатахуун зайлшгүй хэрэгтэй болчхоод байгаа учраас тухайлсан асуудлыг шийдэж байгаа заалтууд дээрээ томъёологдоод орчихсон зүйл. Тэрнээс давхцаж олон ороод байгаа зүйл биш гэдгийг бас анзаарна биз гэж ингэж хэлэх байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Тогтоолынхоо төсөл дээр саналын томъёолол хоёр ч гишүүнээс ирсэн байна уу. Тэмүүлэн гишүүн тогтоолын 3 дугаар заалтын борлуулалтыг дэмжих гэдгийн ард залгуулаад өвөлжилтийн байдал хүндэрсэн сумдад мал, махны явуулын худалдан авалтыг хийх гэдэг заалтыг нэмж оруулаад энэ заалтыг тогтооё гэж байна.

4 дүгээр заалт дээр тэр үйлдвэрлэгчидтэй гэдгийн өмнөх тэжээл гэдгийг авчих хэрэгтэй юм байна. Нэгэнт өвс, тэжээл, био бэлдмэл гээд хэлчихсэн учраас тэжээл үйлдвэрлэгч нартай гээд хэрэггүй юм байна. Тэр өнөө малын тамир юмнуудыг хадгалаад байдаг, сэргээгээд байдаг өнөө био бэлдмэлүүдийнхээ нийлүүлэлтийг бид хийх ёстой. Энийг завсрын зуучлалгүй хийхийн тулд үйлдвэрлэгч нартай нь сумын Онцгой комиссуудыг гэрээ байгуулах зарчмаар явбал арай хямд өртөгтэй очих ийм бололцоо, боломж байна гэж ингэж харагдаад байгаа. Тийм учраас энэ талаас нь хараад хийчихье.

Туваан гишүүний түрүүний ярьсан заалтыг 8 дугаар заалт дээр тэр “хаагдсан зам, давааг нээх” гэдэг үгийг аваад үүнд шаардлагатай хөрөнгийнх нь асуудлыг тэр анхан шатын онцгой комиссынх нь хөрөнгийн дэмжлэг талд багтаагчихъя гэсэн байдлаар оруулчихъя гэж.

Ийм 3 заалт дээр тодотгол аваад даалгах хэсгийн 3 заалттай, чиглэл өгөх хэсгийн 11 заалттай тогтоолын төслийг баталъя гэсэн саналтай байна. Нийгмийн үйлчилгээ гэдэг чинь боловсролын үйлчилгээ орчихоод байгаа юм. Оролгүй

яадаг юм энэ чинь. Эрүүл эрүүл мэнд гэдэг үг нь яагаад тэгж байна вэ гэхээр хөдөөгийн иргэд, малчид, оторчдын эрүүл мэндийн асуудал яригдаад байгаа учраас тэрийг нь тодотгоод нийгмийн үйлчилгээ гэхээр зэрэг бусад бүх үйлчилгээ нь орчхож байгаа байхгүй юу. Энэ нийгмийн салбарынх нь. Болорчулуун гишүүн.

**Х.Болорчулуун:** Тэмүүлэн гишүүний гаргасан саналтай холбогдуулж үг хэлье. Бас явуулын махны худалдан авалтыг дэмжсэн үйл ажиллагааг хийе гэж байна. Явуулын гэдэг үг дэмий байх. Харин махны үйлдвэр, бизнес эрхлэгчдийг агуулах бүхий аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг мах худалдан авахыг эрчимжүүлэх, мөн үүнтэй холбоотой тээврийн зардал дээр зардал гаргах гэдгийг гэж оруулбал зүгээр байх. Сая Шадар сайд бид хоёр ярьсан юм. Онцгой байдлаас бол энэ тээврийн зардал дээр гарах боломжтой гэдгийг бас хэлж байна. Тэгж үгээ оруулбал. Явуульа гэж хэрэггүй байх тэр бол тийм.

**Ж.Батжаргал:** Ерөөсөө хөдөө орон нутагт бэлтгэгдсэн байж байгаа махныхаа нөөцийг маш яаралтай тогтоогоодох, түүнийхээ борлуулалтын үйл ажиллагааг дэмжээдэх л гэж байгаа юм. Дэмждэг арга зам нь юу байна гэхээр зэрэг мах бэлтгэж байгаа аж ахуйн нэгжүүдээ л хуваарилчих хэрэгтэй байна л даа бид. Энэ энэ аймгийн энэ 20 хэдэн сумын махыг энэ махны үйлдвэр, энэ энэ аймгийн тэчнээн сумын махыг энэ үйлдвэр гэхгүй бол бас давхацсан урсгал гүйлгээд баймааргүй байна. Энэ нөхцөл байдал нь өөрөө тийм хойшлуулиггүй бас тийм гамшигийн нөхцөл байдалтай байгаад байгаа учраас зөв зохион байгуулалттай л холбоотой асуудал байхгүй юу. Түрүүн яриад байна лээ манай Тэмүүлэн гишүүн анзаарна биз дээ. Наад Хэмнэлтийн хууль эд нар, тэр өнөө Худалдан авах ажиллагааны хууль эд нар чинь гамшигийн үеийн нөхцөлд хялбаршуулсан үйл явцаар зохион байгуулж явуулдаг заалтыг нь бид

хуулиар нээж өгсөн л зүйл шүү дээ. Хөрөнгө нь төсөвлөгдөөд батлагдчихсан бол тэр хөрөнгөөрөө шийдвэрлэх асуудлаа яг ийм гамшигийн нөхцөл байдлын үед арай хялбаршуулсан байдлаар шийддэг эрх зүйн зохицуулалтыг нь хангаад өгчихсөн.

Харин магадгүй Улсын онцгой комисс орон нутгуудынхаа онцгой комиссын мэдээлэл, дүгнэлт дээр тулгуурлаад яг зудын байдалтай тэр гамшигийн нөхцөл байдал үүсчихсэн сумд, бүс нутгуудынхаа нэр усыг оруулаад баталчих юм бол тэр шийдвэр нь өөрөө уг асуудлаа зохицуулах эрх зүйн гаргалгаа, нээлт нь л болох ёстой л гэж би хараад байгаа шүү дээ мөн үү? Тийм, тэгвэл тэр явуулын гэдэг үгийг авчихлаа тийм үү? Өөр санал байна уу? Байхгүй байхгүй юу. Туваан битгий дар.

**Ц.Туваан:** Ганцхан санал товчхон. Энэ саяын энэ гамшиг, ослын үед иргэдийн амь нас хохироод байгаа шүү дээ төөрчөөд байгаа. Тэгэхээр энэ дээр чинь ерөөсөө нэг л асуудал байгаа шүү дээ. Тэр төөрсөн хүмүүст одоо тийм цахим шийдэл хийгээд өгчихмөөр байгаа юм. Яг тэр байрлаж байгаа цэгээ нэг юм дараад, бид нар моринд жишээлбэл GPS зүүгээд олоод байгаа шиг тийм шийдлийг Цахим харилцаа холбооны яам шийдчих гэвэл Онцгой байдлынхан энэ тэр яг координатаар яваад очоод олоход асуудал байхгүй шүү дээ.

Тэгэхээр саяын хүмүүс чинь гэрээсээ 200 метр, 500 метр энэ тэрд нас барчихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг тэр цэгээ дамжуулдаг энэ шийдлийг нь гаргах юмыг оруулчихвал яадаг юм бэ гэсэн. Энэ олон хүний амь нас аварна шүү.

**Ж.Батжаргал:** Би наадхыг чинь тэр систем нь нээгдчихсэн юм байна, үүссэн кэйс, нөхцөл байдлууд нь болохоор зэрэг өөрийнх нь биед тэр мэдээлэл дамжуулаад байгаа юм нь байхгүй л байгаад байгаа байхгүй юу яг үнэндээ. Гэрээсээ 500 метрийн цаана байгаа

хүнийг бид тэнд байна гэдгийг тогтоодог систем нь байхгүй байна. Байршил тогтоогч нь. Бишээ биш тоног төхөөрөмжийн л асуудал болоод байгаа байхгүй юу. Болж байна тийм заалт авъя, авъя хэдүүлээ. Ариунбуян генерал.

13.32 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

**Г.Ариунбуян:** Энэ Туваан гишүүний дэвшүүлж байгаа саналтай холбоотой манайх энэ дээр хэрэгжүүлж байгаа зүйл бий. Өөрөөр хэлэх юм бол гурван үсэгт хаяг гэдэг ийм технологийг малчин иргэн төөрсөн үед энэ гар утсан дээр, ухаалаг гар утсан дээрээ энэ аппликэйшнийг суулгаад тэгээд онцгой байдлын байгууллага холбогдох байгууллагууд мэдээлэл дамжуулах энэ системийг бид нар туршаад ажиллаад эхэлж байна. Тийм, гол нь малчин иргэддээ үүргийг сурталчлан таниулах, хялбаршуулсан байдлаар үүнийг ойлгуулах асуудлууд байгаа. Тийм.

**Ж.Батжаргал:** Туваан гишүүнээ та саналынхаа томъёоллыг өгчих. Агуулгаар нь бол авчихлаа. Өөр саналтай хүн байна уу? Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээний авлаа. Өшөө энэ заргалдаад салахгүй юм байна.

Тэгвэл тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Саналаа өгсөн биз?

Хуралдаанд оролцсон гишүүдийн 63.6 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Ажлын хэсгийнхээ гишүүдэд баярлалаа. Энд яригдаж, хэлэлцсэн зүйлүүдийг шуурхай ажил хэрэг болгож ажиллаарай. Энэ асуудлыг хэлэлцээж дууслаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хааж байна.